

**ОРОЧУ ШИГҮШ БА ХУТУГ ШИГҮШ ХОЁРЫН ДОЯНЬ УРИАНХАЙ  
АЙМАГТАЙ ХОЛБОГДОХ АСУУДАЛД**

Б. ГЭСЭР

**Товч агуулга:** XVII зуунаас хойших ихэнх Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрын тухай тэмдэглэсэн болно. Тэдний нэг нь Баянмөнх Болху жононгийн хадам эцэг, нөгөө нь Батмөнх Даян хааны хадам эцэг болох бөгөөд тэд XV-XVI зууны үеийн Монголын улс төрийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байв. XVII зуунаас хойших Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрын аль нь Баянмөнх Болху жононгийн хадам эцэг, аль нь Батмөнх Даян хааны хадам эцэг болохыг өөр өөрөөр тэмдэглэж иржээ. Мөн Орочу шигүш болон Хутуг шигүш хоёр аль аймгийн ноёд болохын тухай Монгол болон Хятадын түүхийн сурвалж бичгүүдэд бас адилгүй тэмдэглэжээ. Өмнөх судлаачид түүхийн сурвалж бичгүүдийн адилгүй тэмдэглэлээс болж өөр өөр үзэл санааг дэвшүүлсэн бол тус өгүүлэлд өмнөх судалгааны үр дүнг нягтлан, улмаар Орочу шигүш ба Хутаг шигүш нарын хоорондын харилцаа болон аймаг угсааны харьяаллын тухай өгүүлнэ.

**Түлхүүр үг:** Орочу шигүш, Хутуг шигүш, Уругуд аймаг, Урианхай, Доянь Урианхай.

XVI зуунаас хойших Монголын түүхийн сурвалж бичгүүдийн дунд, “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой” (Цаашид Лувсанданзангийн “Алтан товч” гэнэ), “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Асрагч нэртнийн түүх”, “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж” (Цаашид “Шар тууж” гэнэ), “Алтан хүрдэн мянган хэгээст”, Лувсандамбийжалсангийн “Их Монгол улсын үндсэн Алтан товч тууж оршвой” (Цаашид Лувсандамбийжалсангийн “Алтан товч” гэнэ), Рашпунцагийн “Болор эрих”, Ломигийн “Монголын боржигид овгийн түүх” зэрэг Монголын түүхийн сурвалж бичгүүдэд бүгд Хутуг шигүш болон Орочу

шигүшийн тухай тэмдэглэсэн бий. Түүний дотор “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзаны “Алтан товч”, “Болор эрх”, “Монголын боржигид овгийн түүх”-д зөвхөн Хутуг шигүшийн тухай тэмдэглэсэн, “Шар тууж” болон Лувсандамбийжалсаны “Алтан товч”-д бол зөвхөн Орочу шигүшийн тухай тэмдэглэсэн, харин “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Асрагч нэртийн түүх”, “Алтан хүрдэн мянган хэгээст”-д бол Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын тухай зэрэг тэмдэглэсэн болно. Хятадын Мин улсын үеийн “Мин улсын үнэн тэмдэглэл” (《明实录》“Мин ши лү”) гэх зэргийн түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүшийн тухай тэмдэглэсэн боловч Орочу шигүшийн харьяалал аймгийн тухай болон түүний зарим нарийн зүйлийг тодорхойлон тэмдэглээгүй. Монголын түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд, Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын нэг нь Баянмөнх Болху жононы хадам эцэг, нэг нь Батмөнх Даян хааны хадам эцэг болно. Энэ хоёр хүн бол XV зууны 40-өөд оноос XVI зууны 30-аад оны үед хүртэл, тухайн үеийн Монголын улс төрд чухал үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд Батмөнх Даян хаантай нарийн нягт харьцаатай байжээ. Хятадын Мин улсын түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд Орочу шигүшийг тухайн үеийн Монголын аймаг отгийн дунд Бэлгүдэй ноёны хойч Мулихай ван болон Харчины Болай тайш, Юншээбүгийн Бэгэрсэн тайш нартай нэр алдар зэрэгцсэн хүчирхэг Монголын ноёдын нэг байсан хэмээн тэмдэглэсэн. Хэдийгээр Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Хятадын Мин улсын талын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн нарийн зүйлийг тэмдэглэсэн боловч Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын хоорондын харьцаа, харьяаллын талаарх тэмдэглэл адилгүй өөр өөрөөр тэмдэглэж ирсэн. Энэ нь хойч үеийн түүх судлаачдад Хутаг шигүш болон Орочу шигүш хоорондын харьцаа холбоог тодорхойлоход ихээхэн бэрхшээл, хүндрэл учруулж иржээ.

Д.Гонгор бол Орочу шигүшийг Халхын Урианхай отгийн Уругудын ноён, Баянмөнхийн хадам эцэг гэв<sup>1</sup>. Япон улсын Монголч эрдэмтэн Окада Хидэхиро бол Лувсанданзаны “Алтан товч”-д тэмдэглэсэн Баянмөнх Болху жононы хадам эцэг Хутугт (Хутуг) шигүш болон Батмөнх Даян хааны хадам эцэг хоёрыг Урианхайн ноён бөгөөд эцэг хүү мөн болохыг зөвшөөрч харин Орочу шигүшийн тухай өгүүлсэнгүй. Окада Хидэхиро мөн Хутуг шигүшийн Урианхай бол дараагийн Урианхай түмэн үүссэн Хэнтийн Урианхай мөн гэж үзэв<sup>2</sup>. Монгол

<sup>1</sup> Гонгор, Д., *Халх товчоон*, Улаанбаатар, 1970.

<sup>2</sup> Okada Hidehiro 岡田英弘. 「ウリヤンハン・モンゴル族の滅亡」. 『榎博士頌寿記念東洋史論叢』. (汲古書院). Tokyo: 1988.11.11. 43-58.

улсын эрдэмтэн Ц.Гантулга болон Өвөр Монголын эрдэмтэн Оюунбилэг нар, Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрыг эцэг хүү мөн хэмээн зөвшөөрсөн бөгөөд Хутуг шигүшийг эцэг нь мөн хэмээв<sup>3</sup>. Ц.Гантулга бол Хутуг шигүш, Орочу шигүш хоёрыг Урианхайн ноён хэмээсэн, харин Оюунбилэг бол Орочу шигүшийг Урианхай аймагтай холбож үзээгүй юм<sup>4</sup>. Мөн Л.Жамсран болон Өвөр Монголын эрдэмтэн судлаач Улаан болон Хурц, Юүжи нар Орочу шигүшийг Болай тайшийн харьяат аймаг Харчины нэгэн ноён байсан хэмээн үзжээ<sup>5</sup>. Харин Улаан бол Орочу шигүшийг Баянмөнх жононы хадам эцэг хэмээсэн мөртлөө Хутуг шигүштэй холбож үзсэнгүй<sup>6</sup>.

Монголын түүхийн сурвалж бичгүүдийн дотор Хутуг шигүш болон Орочу шигүшийн тухайд, “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон “Асрагч нэртийн түүх”, “Алтан хүрдэн мянган хэгээст”, “Болор эрих”, “Монголын боржигид овгийн түүх” зэрэг сурвалжуудад Хутуг шигүшийг Баянмөнх Болху жононы хадам эцэг хэмээн тэмдэглэсэн бол “Хаадын үндэсний эрдэнийн товч” болон “Шар тууж”, Лувсандамбийжалсаны “Алтан товч”-д Орочу шигүшийг Баянмөнх Болху жононы хадам эцэг хэмээн тэмдэглэсэн. Хэдийгээр Хутуг шигүшийг Баянмөнх Болху жононы хадам эцэг хэмээн тэмдэглэсэн нь олонтой боловч энэхүү тэмдэглэлийг хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай байх юм.

Нөгөөтээгүүр миний бие Хутуг шигүш нь Орочу шигүштэй нэгэн адил Урианхайн хүн хэмээх Ц.Гантулгын үзлийг дэмжиж байгаа боловч Орочу шигүшийн ноёлж байсан Уругуд аймгийн тухай зайлшгүй тодруулах шаардлагатай хэмээн үзсэн болно. Энэхүү өгүүлэлд өмнө дурдсан эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнг үндэслэн Монгол болон Хятадын түүхийн сурвалж бичгүүдийг шинжлэн судалж, дээрх асуудлуудыг хөндөж, Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын хоорондын харьцаа, Уругуд аймаг болон Урианхай аймаг хоорондын холбооны тухай асуудлыг өгүүлэх болно.

### 1. Орочу шигүш ба Хутуг шигүшийн тухайд

Монголын түүхийн сурвалж бичиг “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-д Орочу шигүш болон Хутуг шигүшийн тухай тэмдэглэлээс үзвэл, “tödüi tende eße tere dörbegüle kegüken i abçu ireged uruγud yin qutuγ tu sigüsi yin dergede yabuba,

<sup>3</sup> Wüyünbilige 乌云毕力格. <金轮千福>所載扎魯特蒙古. 西北民族大学学报. 2010. 6.

<sup>4</sup> Гантулга, Ц., *Алтайн Урианхайчууд*, Улаанбаатар хот: “R&M” хэвлэлийн газар, 2014. т.71.

<sup>5</sup> Жамсран, Л., *Монгол улсын түүх*. 3 боть, Улаанбаатар: 2003. т.67; Hurica 胡日查. 有关朵颜卫者勒蔑家族史实. 内蒙古社会科学. 2000.1; Yuji 玉芝. 蒙古东道诸王及其后裔所属部众历史研究. Докторын ажил. т.23.

<sup>6</sup> Wülan 乌兰. Mengyuyuanliuyanjiu 《蒙古源流》研究. ſenyan: liaoningſengmingzүcүbanſe 辽宁省民族出版社. 2000.

ösügsen-ü qoyina qutuу tu sigüsi siker neretü ökin iyen bolqu jinong tu örgübe.”<sup>7</sup> “Төдий тэндээс тэр дөрвүүл хөвгүүнийг авч ирээд Уругудын Хутугт шигүшийн дэргэд явав, өссөний хойно Хутугт шигүш Шихэр нэрт охиноо Болху жононд өргөв.” Тухайн үед Ойрадын Эсэн тайшид захирагдаж байсан Алтан ургийнхныг дээдэлж явдаг Болай зэрэг дөрвөн түшмэд, нас балчир Баянмөнхийг Эсэний дэргэдээс нуун авч гараад Уругуд аймгийн Хутугт шигүшид хүргэж өгсөн. Энд “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-д Баянмөнх Болхуг хүлээн авч асарсан хүнийг Уругуд аймгийн ноён Хутугт шигүш хэмээв. Хутугт шигүш Баянмөнх Болхуг хамгаалан өсгөсний дараа Шихэр нэртэй охиноо хатан болгож өгсөн.

“Хаадын үндсэн хураангуй алтан товч”-д Батмөнх Даян хааны хатан болон хөвгүүдийн тухайд, “uruуud un qutuу tu sigüsi yin аci ökin samur taiуqu аca geresenje ubasanja qoyar üjegdebe gekü.”<sup>8</sup> “Уругудын Хутугт шигүшийн ач охин Самар тайхэунаас Гэрсэнз, Убасанж хоёр үзэгдэв гэх.” хэмээн тэмдэглэв. Энд Батмөнх Даян хааны бага хатны нэг нь бол Уругуд аймгийн Хутугт шигүшийн ач охин Самар байсан, түүнээс Гэрсэнз, Убасанж хоёр төрсөн хэмээв. “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-оос үзэхэд Хутугт шигүш бол Уругуд аймгийн ноён байсан бөгөөд мөн Батмөнх Даян хааны нагац өвөг нь болно.

Өвөр Монголд мөн “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-ийн нэгэн хуулбар буй. Өвөр Монголын хуулбарт Хутугт шигүшийг Урианхайн ноён хэмээн тэмдэглэжээ<sup>9</sup>.

Лувсанданзаны “Алтан товч”-д “tudui tendeče tere dörbegüle kegüken i abču ireged uriyangqan-u qutuу tu sigüsi yin dergede yabuba, ösügsen-ü qoyina qutuу tu sigüsi sikir neretü ökin iyen bolqu jonong tu ögbe.”<sup>10</sup> “Тэд дөрвүүл хүүхнийг авч ирээд Урианхан Хутугт шигүшийн дэргэд явав. Өссөний хойно Хутугт шигүш Шихэр нэртэй охиноо Болху жононд өргөв”. “uriyangqan-nu qutuу tu şigüši yin аci ökin samur taiуqu аca giresenje, ger bolad qoyar üjigdebe gekü.”<sup>11</sup> “Урианхан Хутугт шигүшийн ач охин Самар тайхэунаас Гэрэсэнжэ (Гэрсэнз), Гэрболад хоёр үзэгдэв” хэмээн тэмдэглэжээ. Үүнд, “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-ийн

<sup>7</sup> *Хаадын үндсэн хураангуй алтан товч*. Эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа. Хянан тохиолдуулсан М.Баярсайхан. Улаанбаатар хот. 2011 он. т.282-283. 64a-64b.

<sup>8</sup> *Хаадын үндсэн хураангуй алтан товч*. Эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа. Хянан тохиолдуулсан М.Баярсайхан. Улаанбаатар хот. 2011 он. т.286. 70a.

<sup>9</sup> Jiajingyan. Jufen Орчуулан тайлбарлав. 贾敬颜. 朱凤译. 汉译蒙古黄金史纲. Kokeqote: Neimengyurenmingcūbanše 内蒙古人民出版社. 1985. т.187. 192.

<sup>10</sup> Лувсанданзан, *Алтан товч*. Улаанбаатар хот. Эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа. Хянан тохиолдуулсан М.Баярсайхан. 2011 он. т.740. 157b.

<sup>11</sup> Лувсанданзан, *Алтан товч*. Улаанбаатар хот. Эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа. Хянан тохиолдуулсан М.Баярсайхан. 2011 он. т.743. 160b-161a.

тэмдэглэсэнтэй ялгаатай нь Хутугт шигүшийг Урианхайн хүн хэмээж, Батмөнх Даян хааны бага хатан Самараас төрсөн нэг хөвгүүнийг Гэрболд хэмээжээ.

Тэгвэл Саган Сэцэний “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д “tere jaγura uruγud un oroču sigüsi sikir neretü ökin iyen tere bayan möngke tayiji da jüngke ergün. ülegsen töröl dür anu kürgey-e kemen tüsigül ün abču sayubai.”<sup>12</sup> “Тэр зуур Уругудын Орочу шигүш Шихэр нэрт охиноо тэр Баянмөнх тайжид жүнгүнээр өргөн, үлдсэн төрөлт нь хүргэе хэмээн түшиглүүлэн авч суубай” хэмээн тэмдэглэжээ. Энд Баянмөнхийг хүлээн авч өсгөж, дараа нь Шихэр нэртэй охиноо түүнд хатан болгон өгсөн хүнийг Уругуд аймгийн Орочу шигүш хэмээн тэмдэглэсэн байна. “tend basa jalayir un qutuγ sigüsi yin ökin sümir qatun ača gerebolad tayiji geresenje tayiji qoyar.”<sup>13</sup> “Тэнд бас Жалайрын Хутуг шигүшийн охин Сүмир хатнаас Гэрэболад тайж, Гэрэсэнжэ тайж хоёр”. Энд Батмөнх Даян хааны Гэрболд болон Гэрсэнз хоёр хөвгүүний эхийг Жалайр аймгийн Хутуг шигүшийн охин Сүмир хэмээн тэмдэглэв. Сүмир хатан бол “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзаны “Алтан товч”-д Самар хэмээн тэмдэглэгдсэн Батмөнх Даян хааны бага хатан болно (“Шар тууж” болон “Асрагч нэртийн түүх”-д Жимсгэн гэж нэрлэнэ. “Шар тууж” болон “Асрагч нэртийн түүх”-ээс үзэхэд хоёр сурвалж бичгийн зохиогч Халх түмнээс гаралтай, тэд Гэрсэнзийн талаар илүү сайн мэдээлэлтэй байж болно. Тиймээс тус өгүүлэлд Жимсгэн хатан гэж нэрлэнэ). Энд “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзаны “Алтан товч”-д тэмдэглэснээс өөр зүйл нь Батмөнх Даян хааны хадам эцгийг Хутугт шигүшийн хөвгүүн бус харин Хутуг шигүш болно.

Жамбагийн “Асрагч нэртийн түүх”-д, “... mongγol un jaq-a du irejü uriγangqan-u qutuγ sigüüsi yin dergede yabuba, qutuγ sigüüsi siker neretü ökin iyen ögčü bayan möngke bolqu jinung kemen nereyidčü yabuba.”<sup>14</sup> “... Монголын захад ирж Урианханы Хутуг шигүшийн дэргэд явав, Хутуг шигүш Шихэр нэрт охиноо өгч, Баянмөнх Болху жонон хэмээн нэрлэж явав”. “uruγud un oroču sigüüsi yin ökin jimis gen qatun yi gerebolud gersenje qoyar.”<sup>15</sup> “Уругудын Орочи шигүшийн охин Жимсгэн хатны Гэрэболд, Гэрэсэнжэ хоёр” гэж тэмдэглэсэн бөгөөд Баянмөнхийг хүлээн авч, мөн охиноо өгсөн хүнийг Урианхайн Хутуг шигүш, харин Батмөнх Даян хааны хадам эцгийг Уругуд аймгийн Орочу шигүш хэмээв.

<sup>12</sup> Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*. Улаанбаатар хот. 2011 он. Эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан. Хянан тохиолдуулсан Ш.Чоймаа. т.481. 58v.

<sup>13</sup> Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*. Улаанбаатар хот. 2011 он. Эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан. Хянан тохиолдуулсан Ш.Чоймаа. т.485. 62 v.

<sup>14</sup> Жамба, *Асрагч нэртийн түүх*. Эх бичгийн цогц судалгаа хийсэн Д.Заяабаатар, Хянан тохиолдуулсан доктор Ш.Чоймаа. Улаанбаатар хот. 2011 он. т.244. 36.а. (11-19).

<sup>15</sup> Жамба, *Асрагч нэртийн түүх*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн Д.Заяабаатар, Хянан тохиолдуулсан доктор Ш.Чоймаа. Улаанбаатар хот. 2011 он. т.246. 38.в. (7-10)

“Шар тууж”-д, “*ᠶаγur-a urγud un oroči sigüsi siker neretü ökin iyen tere bayan möngke tayiji dur jüنگken.*”<sup>16</sup>“Зуур Уругудын Орочи шигүш Шихэр нэрт охиноо тэр Баянмөнх тайж тур жүнгүн болгов”, “*urγud un oroču sigüsi yin ökin jimisgen qatun аса törügсen gere болod, geresenje qoyar buyu.*”<sup>17</sup>“Уругудын Орочу шигүшийн охин Жимсгэн хатнаас төрсөн Гэрэболод, Гэрэсэнжэ хоёр бий” хэмээн Баянмөнхийг хүлээн авсан хүн бөгөөд Батмөнх Даян хааны хадам эцгийг бүгд Уругуд аймгийн Орочу шигүш хэмээн тэмдэглэсэн байна.

“Алтан хүрдэн мянган хэгээст”-д “... *tere dörbegüle uriyangqan nu qutuγ sigüši tur күргеjü ögbe. ösögсen čаγ tur sigüsi. siker neretü ökin iyen ergjü noyan болγan abai.*”<sup>18</sup>, “Тэр дөрвүүл Урианхан Хутуг шигүш дор хүргэж өгөв. Өсгөсөн цаг тур Шигүш Шихэр нэрт охиноо өргөж ноён болгон абай”, “*urγud un orači sigüši yin ökin jimisgin qatun ger болod. geresenje qoyar...*”<sup>19</sup>, “Уругудын Орочи шигүшийн охин Жимсгэн хатан Гэр болд, Гэрэсэнжэ хоёр...” хэмээн Баянмөнхийг хүлээн авсан хүнийг Урианхайн Хутуг шигүш, Батмөнх Даян хааны хадам эцгийг Уругуд аймгийн Орочу шигүш хэмээн тэмдэглэсэн байна.

Рашпунцагийн “Болор эрх” болон Лувсандамбийжалсангийн “Алтан товч”, Ломигийн “Монголын боржигид овгийн түүх”-д мөн Хутуг шигүш болон Орочу шигүшийн тухай тэмдэглэжээ.

Сурвалж бичиг	Нэр	Харьяалал	Батмөнх Даян хаантай харьцаа
“Хаадын үндсэн хураангуй алтан товч”	Хутугт шигүш	Уругуд	Баянмөнхийн хадам эцэг
	Хутугт шигүшийн хөвгүүн	Уругуд	Батмөнх Даян хааны хадам эцэг
“Хаадын үндсэн хураангуй алтан товч” (Өвөр Монгол)	Хутугт шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Хутугт шигүшийн хөвгүүн	Урианхай	Батмөнх Даян хааны хадам эцэг
Лувсанданзаны “Алтан товч”	Хутугт шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Хутугт шигүшийн хөвгүүн	Урианхай	Батмөнх Даян хааны хадам эцэг
“Хаадын үндэсний эрдэнийн товч”	Орочу шигүш	Уругуд	Баянмөнхийн хадам эцэг
	Хутуг шигүш	Жалайр	Батмөнх Даян хааны хадам эцэг

<sup>16</sup> *Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн С.Чулуун, Ш.Цэрэндоо. Улаанбаатар хот. 2011 он. т.119. 17.б.

<sup>17</sup> *Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн С.Чулуун, Ш.Цэрэндоо. Улаанбаатар хот. 2011 он. 122. 20.а.

<sup>18</sup> Darma, altan хүрдүн mingγan hegesütü, Coij hinaba. öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. 121.

<sup>19</sup> Darma, altan хүрдүн mingγan hegesütü, Coij hinaba. öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. 129.

“Асрагч нэргийн түүх”	Хутуг шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Орочу шигүш	Уругуд	Батмөнх Даян хааны хадам эцэг
“Шар тууж”	Орочу шигүш	Уругуд	Баянмөнхийн хадам эцэг
	Орочу шигүш	Уругуд	Батмөнх Даян хааны хадам эцэг
“Алтан хүрдэн мянган хэгээст”	Хутуг шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Орочу шигүш	Уругуд	Батмөнх Даян хааны хадам эцэг
“Болор эрих” <sup>20</sup>	Хутуг шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Шигүш	Урианхай	Батмөнх Даян хааны хадам эцэг
Лувсандамбийжалсан “Алтан товч” <sup>21</sup>	Орочу шигүш	Урунхад	Баянмөнхийн хадам эцэг
“Монголын боржигид овгийн түүх” <sup>22</sup>	Хутуг шигүш	Урианхай	Баянмөнхийн хадам эцэг
	Хутуг шигүшийн хөвгүүн	Урианхай	Батмөнх Даян хааны хадам эцэг

(Дээр “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д Орочу шигүшийг Орочу шигүш “oroču sigüsi”, “Асрагч нэргийн түүх” болон “Шар тууж”-д бол Орочи шигүш “oroči sigüüsi”, “Алтан хүрдэн мянган хэгээст”-д Орачи шигүш “orači sigüsi” хэмээн тэмдэглэсэн юм. Тус өгүүлэлд “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д тэмдэглэсэн Орочу шигүш хэмээснээр нэрлэнэ).

Монголын түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзаны “Алтан товч”-д Баянмөнх Болху жононгийн хадам эцэг нь “Хутугт шигүш” хэмээн тэмдэглэгдсэн бол, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Асрагч нэргийн түүх”, “Алтан хүрдэн мянган хэгээст”, “Монголын Боржигид овгийн түүх” болон “Болор эрих”-д бүгд “Хутуг шигүш” хэмээн тэмдэглэгдсэн байна. Эдгээр сурвалж бичгүүдийн дунд зарим нэгэн нь “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-ийг ашигласан нь тодорхой байсан боловч, түүний “Хутугт” хэмээх нэрийг хүлээн зөвшөөрөөгүйгээс үзвэл ихэнх түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн “Хутуг шигүш” нь илүү оновчтой байж болох юм.

Дээр дурдсан Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Хутуг шигүш болон Орочу шигүштэй холбогдох түүхийн үйл явдал адилхан тэмдэглэсэн боловч,

<sup>20</sup> Rašipungčuy. bolor erihe. öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. 354. 366.

<sup>21</sup> Luvsandanbijalsan, *Их монгол улсын үндсэн алтан товч тууж оршбой*, 大蒙古国根本黄金史. Kökeqot: neimengyudašiuecubanše 内蒙古大学出版社. 2014. 175.

<sup>22</sup> Lomi 罗密. *Монголын Боржигид овгийн түүх* 蒙古博尔济武氏族谱. Kökeqot: neimengyudašiuecubanše 内蒙古大学出版社. 2014. 136. 16 v. 145. 2v.



холбогдох хоёр гол баатрын нэрийг харин өөр өөрөөр тэмдэглэсэн байна. Үүнд, Баянмөнх Болхуг хүлээн авч, асарч, охиноо өгсөн хүн бөгөөд Батмөнх Даян хааны хадам эцэг болсон хоёр үйл явдалд Хутуг шигүш болон Орочу шигүш хоёр салсангүйгээс үзэхэд, энэхүү хоёр хүний хооронд нарийн нягт харьцаа байгаа нь тодорхой юм. “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзаны “Алтан товч”-д Орочу шигүшийг дурдсангүй боловч, бусад Монголын түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэснээс үзэхэд, тэрээр Хутуг шигүштэй эцэг хүүгийн харьцаатай нь илэрхий болно. Гэтэл тэдний хэн нь эцэг, хэн нь хүү болох тухайд дээр дурдсан түүхийн сурвалж бичгүүдэд маш будлиантай тэмдэглэжээ. Урьд судалгаа хийсэн Д.Гонгор болон Өвөр Монголын Улаан нь Орочу шигүшийг Баянмөнх жононгийн хадам эцэг гэж үзсэн<sup>23</sup> бол Япон улсын Окада Хидэхиро болон Ц.Гантулга нар Хутуг шигүшийг эцэг нь гэж үзжээ.

Япон улсын Монголч эрдэмтэн Окада Хидэхиро “Урианхай Монголын сүйрэл” гэсэн өгүүлэлдээ “ダヤン・ハーンの在世中、ウリヤンハンはハーンと特に縁故の深い部族であったようである。「アルタン・トブチ」に依ると、ダヤン・ハーンの父バヤン・モンケ・ボルフ晋王は、チンギス・ハーンの後裔を父とし、オイラトのエセン・ハーンの女を母としてオイラトに生まれ、四人の勇士に護送されてモンゴルのウリヤンハンのフトクト小師の営に至り、その女シキルと婚し、バト・モンケ・ダヤン・ハーンを生んだのである。”<sup>24</sup>, “Даян хааныг амьд байхад, Урианхай нь хаантай онц гүн харьцаатай байв. “Алтан товч”-д тэмдэглэснээр, Даян хааны эцэг Баянмөнх жононы эцэг нь Чингис хааны хойч үеийнх мөн, эх нь Эсэн хааны охин, Баянмөнх жононг Ойрадад төрөөд, дөрвөн баатраар хүргүүлэн Урианхайн Хутугт шигүшийн дэргэд нь очиж, Хутугт шигүшийн охинтой нь хуримлан Батмөнх Даян хааныг төрүүлэв.” хэмээн хоёр “Алтан товч”-д тэмдэглэсэн Хутугт шигүш бол Батмөнх Даян хааны нагац өвөг болохыг зөвшөөрсөн. Өвөр Монголын судлаач Оюунбилэг “1470年、兀魯兀部人、达延汗的舅父斡罗出少士率众进入黄河河套，与满都古勒汗、博罗呼济农和札加思兰会合。”<sup>25</sup>, “1470 онд, Уругуд аймгийн хүн, Даян хааны нагац ах Орочу шигүш нь их цэргээ дагуулан Шар мөрний Бортохойд орж, Мандуул хаан болон Болху жонон, Бэгэрсэнтэй нийлэв” хэмээн Орочу шигүшийг Батмөнх Даян хааны нагац ах гэж бичжээ. Өөрөөр хэлбэл Оюунбилэгийн зүгээс, Хутуг шигүш, Орочу шигүш хоёрыг эцэг хүүгийн харьцаатайг зөвшөөрсөн байна. Гэхдээ тэрээр

<sup>23</sup> Гонгор, Д. *Халх товчоон*, Улаанбаатар: 1970. т.152.

<sup>24</sup> Okada Hidehiro 岡田英弘. 「ウリヤンハン・モンゴル族の滅亡」. 『榎博士頌寿記念東洋史論叢』. (汲古書院). Tokyo: 1988 .11.11. 43-58.

<sup>25</sup> Wüyünbilige 乌云毕力格. <金轮千福>所载扎鲁特蒙古. 西北民族大学学报. 2010. 6.



Батмөнх Даян хааны хадам эцэг нь хэн болохыг тодорхойлсонгүй. Ц.Гантулга, “Гэрэболд, Гэрсэнз нарын эх Жимсгэнэ хатан (Самар тайхэү ч гэдэг) бол Баянмөнх Болху жононд Шихэр нэрт охиноо сүйлж өгсөн, Урианхайн Хутугт Шигүшийн хөвгүүн Оруч шигүшийн охин бөгөөд түүний эх нь Жалайр аймгийн хүн байсан бололтой юм”<sup>26</sup> хэмээн Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрын эцэг хүүгийн харьцааг тодорхойлсон боловч мөн Оюунбилэгийн адил Хутуг шигүшийг эцэг, Орочу шигүшийг хүү хэмээн үзжээ. Мөн Өвөр Монголын судлаач Улаан, “孛罗忽依靠岳父斡罗出少师的力量逐渐壮大自己, 不久就由‘穷寇’一变而为与满都鲁、札加思兰时常联名出现的大人物”<sup>27</sup>, “Болху түүний хадам эцэг Орочу шигүшийн хүчийг түшин аажмаар хүчирхэг болж, удалгүй Мандуул, Бэгэрсэнтэй нэр зэрэгцэн тэмдэглэгдэх болсон” хэмээн “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д тэмдэглэснийг баримтлан Орочу шигүшийг Баянмөнх Болху жононгийн хадам эцэг гэж үзсэн ажээ.

Монголын түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Шар тууж” болон Лувсандамбийжалсангийн “Алтан товч”-д Орочу шигүшийг Баянмөнх Болхугийн хадам эцэг хэмээн, харин бусад түүхийн сурвалж бичгүүдэд Хутуг шигүшийг Баянмөнх Болхугийн хадам эцэг хэмээн тус тус тэмдэглэсэн байна. Тиймээс Монголын түүхийн сурвалж бичгүүдийн тэмдэглэж үлдээсэн мэдээллүүд нь Хутуг шигүш болон Орочу шигүш хоёрын хэн нь эцэг, хэн нь хүү байсныг тодруулахад хангалттай биш юм.

Хятадын Мин улсын үеийн Монголтой холбогдох түүхийн сурвалж бичгүүдийн Ма Вэншэн (马文升) -ий “Ши жэн ши чэн жи” 《西征石城记》-д Орочу шигүшийн тухай тэмдэглэлийг нягтлан үзвэл, “正统己巳年 (1449年), 虏酋也先寇大同、宣府, 脱脱卜花王寇辽东, 阿乐出寇陕西, 土达渐遭剽掠。”<sup>28</sup> “Жэнтунгийн шарагчин могой жил (1449 он)-д, дайсны ахлагч Эсэн Датун, Сюаньфуг, Тогтобух ван Ляодунг, Алэчу Шаньсиг дайран, Түда нар аажмаар дээрэмдүүлж эхлэв.” Бас Жан-Ю (张雨) -гийн “Бянь жэн као” 《边政考》-д тэмдэглэснээр, “十四年 (正统 1449年) 北虏阿渠寇陕西平凉。是年, 北虏也仙寇大同, 有土木之变。”<sup>29</sup> “Арван дөрөвдүгээр онд (Жэнтун, 1449 он)

<sup>26</sup> Гантулга, Ц., *Алтайн Урианхайчууд*, Улаанбаатар хот, 2014. т.71.

<sup>27</sup> Wulan 乌兰. Mengyuyuanliuyanjiu 《蒙古源流》研究. senyan: liaoningshengmingzucubanse 辽宁省民族出版社. 2000. 340. тайлбар: 73.

<sup>28</sup> Mawenšen 马文升. sijenshichenji 西征石城记. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. Kökeqota: neimengyudašuecubanse. 2006. 115.

<sup>29</sup> Jangyu 张雨. Bianjengkao 边政考. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. kökeqota: neimengyudašuecubanse. 2006. 171. wangciung 王琼. beilusiliue 北虏事迹. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. Kökeqota: neimengyudašuecubanse. 2006. 130.

умард зүгийн дайсан Ачиү нь Шаньсигийн Пинлянгийг дайрав. Мөн тэр онд умард зүгийн дайсан Эсэн Датунг довтолж, “Түмүгийн хувиралт” болов.” (Энд “阿乐出” “А-лө-чү”, “阿渠” “А-чү” бол Орочу шигүшийн хятад дуудлага юм. Мөн “Мин улсын үнэн тэмдэглэл” зэрэг Хятадын Мин улсын үеийн сурвалж бичигт “А-луо-чү” 阿罗出<sup>30</sup>, “Волуочү шаоши” 斡罗出少师<sup>31</sup>, “Алаочү сяоши ван” 阿老出小石王<sup>32</sup> хэмээн тэмдэглэсэн). Орочу шигүш 1449 оноос эхлэн Шар мөрний Бортохойд орж, Хятадын Шаньсигийн хил дагуу хотуудыг дайрч эхэлжээ. Өөрөөр хэлбэл Орочу шигүш 1449 оны үед нэгэнт эрийн цээнд хүрсэн, Монголын аймаг, отгуудын дунд нэр алдартай, хүчирхэг удирдагч болсон ажээ.

“Асрагч нэртийн түүх”-д Гэрсэнзийг эм хар тахиа жилд (1513 он) төрсөн<sup>33</sup> хэмээн тэмдэглэснээс үзэхэд, хэрвээ Орочу шигүш нь Хутуг шигүшийн хүү, Батмөнх Даян хааны хадам эцэг нь байсан бол, түүний охин Жимсгэн хатан наад захад нь түүнийг 80, 90-ээд настай үед нь Батмөнх Даян хаанд хатан болсон болно. Энэ нь үнэн бодит байдалд нийцэхгүй юм. Мөн “Мин улсын үнэн тэмдэглэл” болон бусад Мин улсын талын түүхийн сурвалж бичгүүдээс үзвэл, “天顺 (1457-1464) 间, 虏酋阿罗出入居之, 时出劫掠。成化初, 毛里海、乧加思兰、孛罗忽、满都鲁继至, 初犹去住不常, 六年以后, 始为久居计”<sup>34</sup>, “Тяньшүнгийн онуудад (1457-1464), дайсны ахлагч Алуочү (Бор тохойд) нүүж орсон, үе үе дээрэм хийдэг. Чэнхуа (1465)-наас эхлэн, Мулихай, Бэгэрсэн, Болху, Мандуул хойно хойноос хүрэлцэн ирсэн, анх тэд ирж очдог байсан бол, (Чэнхуагийн) зургадугаар оноос суурьших болов” (Энд Болху нь Баянмөнх Болхуг тэмдэглэсэн). 1465 оноос хойш Баянмөнх Болхутай хамт Бортохойд нүүж орсон хүн бол Орочу шигүш байсан, харин Хутуг шигүшийн тухай огт дурдсангүй. Өөрөөр хэлбэл тухайн үед Баянмөнх Болхуг Орочу шигүш хамгаалан явж байсан. Тиймээс “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Шар тууж” болон Лувсандамбийжалсаны “Алтан товч”-д тэмдэглэсэн Орочу шигүш бол Баянмөнх Болхугийн хадам эцэг болох нь түүхийн үнэн байдалтай илүү нийцэх юм. Өөрөөр хэлбэл Орочу шигүш нь эцэг, Хутуг шигүш нь хүү болно.

<sup>30</sup> Min yingzǔng shìlù 明英宗实录, Тианшүнгийн тавдугаар оны наймдугаар сарын шарагчин могой өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>31</sup> Min shìanzǔng shìlù 明宪宗实录, 38 бүлэг. Чэнхуагийн гуравдугаар оны хаврын цагаан сарын улаан хулган өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>32</sup> Min shìanzǔng shìlù 明宪宗实录, 79 бүлэг. Чэнхуагийн зургадугаар оны тавдугаар сар. Taiwan: 中央研究院历史语言研究所. shìrìjiǔ 徐日久. wubianbianze 五边典则. 1 бүлэг. 明代蒙古汉籍史料汇编. 第五辑. Kökeqota: neimengyudašüecubānšē. 2006. 13.

<sup>33</sup> Жамба, *Асрагч нэртийн түүх*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн Д.Заяабаатар, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011. 255-256. 47б-48а.

<sup>34</sup> Fangkǔnjiǎo 方孔炤. Míncuānbianliuejì 明全边略记. 4-бүлэг. 明代蒙古汉籍史料汇编. 第三辑. Kökeqota: neimengyudašüecubānšē. 2006.. 149.

## 2. Орочу шигүш хийгээд Уругуд аймгийн тухайд

Орочу шигүш болон Хутуг шигүшийн харьяа аймгийн тухайд судалгаа хийсэн голлох судлаачид нь Япон улсын Вада Сэй, Окада Хидэхиро, Монгол улсын Д.Гонгор, Л.Жамсран, Ц.Гантулга болон Өвөр Монголын Оюунбилэг, Улаан, Хурц, Юү Жи нар болно.

Вада Сэй, “阿羅出がなほは此の後も姑く河套に據いて孛羅忽太子を助け、頗る活躍したことは前述のごとく明の記載に著はれている。私は斯ういふ関係、即ち阿羅出が恐らく孛羅忽太子を助けて毛里孩を伐つた鄂羅郭特の烏訥博羅特王の父巴圖爾錫古蘇特一名Orojuが即ち此の阿羅出に相違ないと思ふ。”<sup>35</sup>, “Алөчу үүнээс хойш мөн Бортохойг түшиглэн Болху тайжийг тусалж маш нэр цуутай байсан нь өмнө тодорхой өгүүлсэн. Миний бие энэхүү харьцааны тухайд, Алөчу бол Болху тайжийг тусалж Мулихайг дайтсан Уругудын Өнөболд вангийн эцэг Баатар Шигүүшдэйгийн нөгөө нэгэн нэр “Oroju” болох нь лавтай гэж бодно” хэмээн Орочу шигүшийг Хавт Хасарын хойч үеийн Шигүүшдэй гэж үзжээ. Окада Хидэхиро нь Хутуг шигүшийн харьяалал аймгийн тухайд, “かくの如くウリヤンハンはダヤン・ハーンの母の出身部族だったのであるから、ハーンはその在世中、ウリヤンハンに対して特に愛顧を加えたことは想像に難しくない。しかしハーンの死後ともなると、篡奪者バルスボラト晋王も、嫡嗣ボディ・アラク・ハーンも、もはやウリヤンハン氏の出ではなく、特別の関係はなかった。そうした部族の立場の変化が、ウリヤンハンの叛乱を惹き起し、万戸の解体をもたらしたのであらうと考えてよからう。”<sup>36</sup>, “Урианхай түмэн бол Даян хааны ээжийн төрсөн аймаг учраас Даян хааныг амьд байхад тус аймагт онцгой хандлагатай байхыг төсөөлж болно. Гэтэл Батмөнх Даян хааныг нас барсны дараа, хаан ширээг булаасан Барсболд болон дараа нь хаан ширээнд суусан Боди Алаг нь бүгд Урианхай гаралтай бус болохоор, Урианхайтай онц харьцаагүй болсон. Тиймээс тус аймгийн байр суурь нь өөрчлөгдсөнөөс болж Урианхай түмэн бослого хийж, эцэст нь сөнөхөд хүрсэн” хэмээн өгүүлжээ. Үүнд, Окада Хидэхиро Лувсанданзангийн “Алтан товч”-д тэмдэглэсэн Хутуг шигүш болон түүний хүүг Урианхайн ноён гэж зөвшөөрчээ.

Д.Гонгор “Халх товчоон” бүтээлдээ, “Баянмөнхөд Халх Урианхайн отгийн Урудын Урууч шигүши Шихэр нэрт охиноо сүйлэн өгсөн байна”<sup>37</sup> хэмээн Орочу

<sup>35</sup> Wada Sei 和田清. 「東亜史研究・蒙古篇」. 東洋文庫. 1958. 388.

<sup>36</sup> Okada Hidehiro 岡田英弘. 「ウリヤンハン・モンゴル族の滅亡」. 『榎博士頌寿記念東洋史論叢』. (汲古書院). Toukyo: 1988 .11.11 . 43-58.

<sup>37</sup> Гонгор, Д., *Халх товчоон*, Улаанбаатар, 1970. т.152.

шигүшийг Халхын Урианхай отгийн Уругудын хүн гэж үзжээ. Л.Жамсран “Монголын дундад зууны үеийн түүх” бүтээлдээ Орочу шигүшийн тухайд, “Тэрхүү Алчу ноён нь Болайн аймгийн толгойлогчийн нэг байсан ба Болай, Мулихай ван нартай хамтран үйл ажиллагаа явуулж байжээ”<sup>38</sup> хэмээн өгүүлжээ. Тухайн үед Болай тайш бол Харчин аймгийн ноён байсан. Өөрөөр хэлбэл Л.Жамсран Орочу шигүшийг Харчин аймгийн нэгэн ноён байсан хэмээн үзсэн болно. Улаан болон Хурц нар мөн Орочу шигүшийг Болай тайшийн ноёлж байсан Харчин аймгийн нэгэн ноён байсан гэж үзсэн<sup>39</sup>. Юүжи докторын өгүүлэлдээ, “因新立的摩伦汗不听毛里海摆布, 转而依靠原孛来部下斡罗出, 于是毛里海在成化二年(1466年)九月杀死摩伦汗, 驱逐了斡罗出。”<sup>40</sup>, “Шинээр хаан ширээнд суусан Молон хаан нь Мулихайгийн санаагаар явахгүй учраас Болайгийн харьяат Орочу шигүшид түшихээр болсон. Ингээд Мулихай Чэнхуагийн хоёрдугаар оны (1466 он) есдүгээр сард Молон хааныг хөнөөж Орочу шигүшийг хөөсөн” хэмээн өгүүлжээ. “Мин улсын үнэн тэмдэглэл”-д энэ үйл явдлын талаар “孛来太师近杀死马儿苦儿吉思可汗, 毛里海又杀死孛来, 后又新立一可汗, 有斡罗出少师者, 与毛里海相仇杀, 毛里海又杀死新立可汗, 逐斡罗出, 今国中无事, 欲求通好。”<sup>41</sup>, “Ойрд Болай тайш Маркус хааныг хөнөөгөөд, Мулихай дахин Болайг алж шинээр нэг хаан өргөв. Орочу шигүш хэмээх хүн Мулихайтай дайсагнав. Мулихай дахин шинэ хаанаа хөнөөж Орочу шигүшийг хөөсөн. Одоо Монголын дотоодод тайван болсон болохоор бид нартай найрамдалтай харьцахыг хүсэв” хэмээсэн ба мөн “Мин улсын үнэн тэмдэглэл”-д, “孛来下大头目阿罗出”<sup>42</sup>, “Болайгийн доорх их толгойлогч Орочу” хэмээн тэмдэглэсэн байна. Л.Жамсран, Улаан, Хурц, Юүжи нар энэхүү тэмдэглэлийг үндэслэн Орочу шигүшийг Болай тайшийн доор Харчин аймгийн нэгэн ноён мөн хэмээх дүгнэлт хийсэн бололтой. Тэгвэл тухайн цаг үед Монголын алтан ургийн удмынхныг дэмжсэн аймгийн ноёд бүгд Муни уулын Шар мөрний Бортохой<sup>43</sup>-д нүүж очсон байсан учир энэхүү тэмдэглэлээр Орочу шигүшийг Болай тайшийн харьяат болохыг баталж чадахгүй юм. Дээр дурдсан Хятадын Мин улсын сурвалж бичигт тэмдэглэсэнээр Орочу шигүш аль 1449

<sup>38</sup> Жамсран, Л., *Монгол улсын түүх*, боть 3, Улаанбаатар: 2003. 67.

<sup>39</sup> Wūlan 乌兰. Mengyuyuanliuyanjiu 《蒙古源流》研究. ſenyan: liaoningſengmingzūcūbanſe 辽宁省民族出版社. 2000. 330. Hūriča 胡日查. 有关朵颜卫者勒蔑家族史实. 内蒙古社会科学. 2000. 1.

<sup>40</sup> Yūji 玉芝. 蒙古东道诸王及其后裔所属部众历史研究. Докторын ажил. т.23.

<sup>41</sup> Min ſianzūng ſilu 明宪宗实录, 38 бүлэг. Чэнхуагийн гуравдугаар оны хаврын цагаан сарын улаан хулган өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>42</sup> Min yingzūng ſilu 明英宗实录, Тианшүнгийн тавдугаар оны наймдугаар сарын шарагчин могой өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>43</sup> Одоогийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотын өмнө болон Ордос хотын хойд, Богт болон Хөх хотын Шар мөрний урсгалын дагуу.

оноос эхлэн нэгэнт өөрийн харьяат аймгаа дагуулан Муни уулын Шар мөрний Бортохойд орж гардаг болсон, Болай тайш Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэснээр 1454 он хүртэл Ойрадын Эсэн тайшийн харьяанд байж, Баянмөнх Болхуг Ойрадаас нуун авч гараад Орочу шигүшид хүлээлгэн өгсөн зэргээс үзвэл, Орочу шигүшийг Болай тайшийн Харчин аймагт харьяалагдах дүгнэлт нь андуурал гэж үзэж болно.

Оюунбилэг “Өвөр Монголын нэвтэрхий түүх” (《内蒙古通史》) бүтээлийнхээ дөрөвдүгээр бүлэгт “也先诱杀阿噶巴尔津济农时，济农的儿子哈尔固楚克在逃跑途中也被杀害，其妻生下遗腹子伯颜猛克，后来被送至兀良哈斡罗出少师处，斡罗出少师将女儿失吉儿嫁给伯颜猛克，并把伯颜猛克夫妻送至其叔祖父满都鲁汗处。”<sup>44</sup>, “Эсэн Агбаржин жононг аргаар алах үед, жононы хөвгүүн Харагчу мөн дүрвэхийн замд алуулсан. Түүний эхнэрээс Баянмөнх хэмээх хөвгүүн төрүүлж дараа нь Урианхай Орочу шигүшийн дэргэд хүргүүлэн, Орочу шигүш охин Шихирийг Баянмөнхөд хатан болгон өргөж, тэр хоёрыг тэдний авга өвөг Мандуул хааны дэргэд нь хүргэв.” хэмээн Орочу шигүшийг Урианхайн хүн бөгөөд Баянмөнхийн хадам эцэг хэмээн зөвшөөрсөн мөртлөө дараа нь, “革儿孛罗舅家是阿老出之子。阿老出出身五投下乌鲁贵族，曾是哈刺陈氏贵族太师孛罗来部下。后来，阿老出部众被乧加思兰吞并，成为应绍不万户下的塔不乃麻（意为“五部”、“五投下”）鄂托克。阿老出女为达延汗母，孙女为达延汗妃子，生革儿孛罗。”<sup>45</sup>, “Гэрболдын нагацын тал бол Алочугийн хөвгүүн. Алочу бол зүүн Монголын таван аймгийн Уругуд язгууртны гэр бүлээс гаралтай, Харчин аймгийн язгууртан тайш Болайгийн харьяат. Дараа нь Алочугийн харьяат аймаг нь Бэгэрсэнд эзлэгдэн Юншээбү түмний Таван Найман отог болов. Алочугийн охин бол Даян хааны ээж, ач охин бол Даян хааны хатан, түүнээс Гэрболд төрсөн.” хэмээн Батмөнх Даян хааны ээжийг Орочу (斡罗出) шигүш буюу Алочу (阿老出) -гийн охин гэж зөвшөөрсөн мөртлөө Орочу шигүшийг Урианхайн хүн, харин Алочуг Уругуд аймгийн хүн хэмээн хоёр өөр хүн гэж өгүүлсэн байна. Оюунбилэг өөр нэгэн өгүүлэлдээ, Орочу шигүшийн тухайд “1470年，兀鲁兀部人，达延汗的舅父斡罗出少士率众进入黄河河套，与满都古勒汗，博罗呼济农和乧加思兰会合。不久，斡罗出被乧加思兰逐出河套，他所率领的塔不乃麻鄂托克被乧加思兰吞并，融入到后来的应绍卜万户里。”<sup>46</sup>, “1470 онд, Уругуд аймгийн хүн, Даян хааны нагац ах Орочу шигүш харьяатаа дагуулан Шар мөрний Бортохойд

<sup>44</sup> Wüyünbilige 乌云毕力格. Neimengyütünshi 内蒙古通史. Боть 4. Beijing: Renmingcubanshe. 2011. 94.

<sup>45</sup> Wüyünbilige 乌云毕力格. Neimengyütünshi 内蒙古通史. Боть 4. Beijing: Renmingcubanshe. 2011. 105.

<sup>46</sup> Wüyünbilige 乌云毕力格. <金轮千禧>所載扎魯特蒙古. 西北民族大学学报. 2010. 6.

нүүн орж, Мандуул хаан болон Болху жонон, Бэгэрсэнтэй нийлсэн. Удалгүй Бэгэрсэн Орочу шигүшийг Бортохойгоос хөөн гаргаж, түүний удирдаж байсан Таван Найман отгийг булаан авч, сүүлд нь Юншээбү түмэнд оруулав.” гээд Орочу шигүшийг Уругуд аймгийн хүн, Батмөнх Даян хааны нагац ах гэж үзжээ.

Дээр дурдсанаар Окада Хидэхиро Лувсанданзангийн “Алтан товч”-д тэмдэглэсэн Хутуг шигүшийг Урианхайн хүн гэдгийг зөвшөөрсөн атлаа түүний эцэг Орочу шигүш болон Уругуд аймагтай холбож үзээгүй юм. Мөн Өвөр Монголын судлаач Улаан, Хурц, Юүжи нар зөвхөн Орочу шигүшийг тусдаа судалж Хутуг шигүштэй холбож үзсэнгүй. Хэдийгээр ихэнх Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүшийг Уругуд аймгийн хүн хэмээн тэмдэглэсэн боловч, Лувсанданзангийн “Алтан товч” болон Рашпунцагийн “Болор эрих”, Лувсанданбийжалсангийн “Алтан товч”, “Монголын Боржигид овгийн түүх”-д Орочу шигүшийг бас Урианхайн хүн хэмээн тэмдэглэсэн билээ. Уругуд аймаг бол Урианхайтай харьцуулбал харьцангуй жижиг аймаг отог болно, тухайн үед Урианхайд харьяалагдах магадлал их байв. Юань улсын үед Отчигин ноёны зүүн гарын чинсан Мухлайгийн хойч үеийнхэд харьяалагдах Жалайр, Уругуд, Мангуд, Ихэрэс, Хонгирад гэх таван аймаг нь Доянь Урианхайн зүүн бөгөөд урд талд нутагладаг байв<sup>47</sup>. Мухлайгийн хойч үеийн Нагачу нь Мин улсад бууж өгсөний дараа, Доянь Урианхай болон Отчигины хойч үеийнх тэдний хуучин нутгийг эзлэв.

Хятадын Мин улсын үеийн түүхийн сурвалж бичигт тэмдэглэснээр, XVI зууны сүүлч, XVII зууны эхээр Уругуд аймаг хоёр бүлэг байсан бөгөөд нэг нь Цахар түмэнд харьяалагдаж, нөгөө нэг бүлэг нь Түмэд түмэнд харьяалагдаж байв. “Ляо и люэ” 《辽夷略》-д тэмдэглэснээр, “离广宁、镇静、镇边、镇远等堡三百余里而牧，其市赏仍由镇远者，有五路。”<sup>48</sup>, “Гуаннин, Жэнжинь, Жэнбянь, Жэнюань зэрэг цайзаас 300 гаран газрын (150 км гаран) зайд нутаглаж, мөн Жэнюаниас захын шагнал авах нь Улү болно.” Энд Улү (五路) нь Уругуд гэсэн хятад дуудлага бөгөөд тухайн үеийн Хятадын зүүн талын хилийн Гуаннин, Жэнжинь, Жэнбянь, Жэнюаниаас 150 км гаран зайд нутаглаж байжээ. “Манжийн хуучин данс”-д тэмдэглэснээр, “dahame jihe urutgurun i minggan beile, buyantai efu be olji baha komso, baha honin be mamgiyafi bahakū seme geren de ačabume beñjheku, olji be susai boigon ara sehengge arahakū, siden i olji emu ihan be minggan beile ini

<sup>47</sup> Song Lian 宋濂. Yuanshi 元史. Боть 119. Beijing: zhonghuashuju. 1976.

<sup>48</sup> Zhangnai 张鼐. liaoyiliue 辽夷略. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 476.



booi dalingho i monggo de enčuleme buhe.”<sup>49</sup>, “Тэд дагаж ирсэн Урут ( Уругуд ) гүрний Мянган бэйл, Буянтай эфү нар олзолсон хүнс, олзолсон хонио бусадтай хамт хүргэж ирэхгүйгээр дур мэдэн алж идээд, дараа нь олзолсон зүйл байхгүй хэмээн ам нийлэн хэлсэн. Олзолсон хүнээ тавийн өрхөд оруулна гэсэн амлалтдаа хүрээгүй. Хамт олзолсон нэг үхрийг Мянган бэйлийн Далинхэд байх өөрийн гэрийн Монгол хүнд өгөв.” Манж Зүрчидийн Нурхачийн байгуулсан Хойд Алтан улсын үед Уругуд аймаг Аохан, Найман ба Зүүн Түмэд аймгийн хоорондох Далэнхэ (大凌河. Монголоор Ойн гол гэдэг)-гийн дунд урсгалын ойр хавьд нутаглаж байсан. Энэ нь “Ляо и люэ”-д тэмдэглэсэнтэй нийцнэ. Хятадын судлаач Дү Жяжи (杜家驥) мөн тухайн үед Уругуд аймгийг өнөөгийн Өвөр Монголын Хүрээ хошууны хавьцаа байсан хэмээн үзжээ<sup>50</sup>. Иймээс энэ бүлэг Уругуд аймаг нь XV зуунаас өмнөх үеийн нутгаас холдоогүй. Мин улсын үеийн түүхийн сурвалж бичиг “Хуан мин жи фан ди ту” 《皇明职方地图》-д тэмдэглэснээр, “朵颜东起广宁前屯, 历喜峰, 近宣府.”<sup>51</sup>, “Доянь (Урианхай) зүүн тал Гуаннин Чيانьтунаас Баясгалант хадат хаалгыг өнгөрөн Сюаньфуд ойртоно” гэжээ. Мөн Мин улсын үеийн Вэй Хуан (魏焕) зохиосон “Жю бянх као” 《九边考》-д Доянь Урианхайн нутгийн хязгаарыг “Хуан мин жи фан ди ту”-тай адилхан тэмдэглэжээ<sup>52</sup>. Өөрөөр хэлбэл XVII зууны эхэн үед Уругуд аймгийн нутаглаж байсан газар нь Доянь Урианхай захирч байсан цар хүрээнд байв. Иймээс газар зүйн талаар үзэхэд энэ бүлэг Уругуд аймаг нь Доянь Урианхайд багтаж байв.

Нөгөө бүлэг Уругуд бол “ Жю бянх као ”-д тэмдэглэснээр, “满官嗔部下为营者八, 旧属火筛, 今则大酋俺答阿不孩领之, 为营六, 曰多罗土闷, 曰畏吾儿, 曰兀甚, 曰叭要, 曰兀鲁, 曰土吉喇。三部兵约共七万, 俱住牧套内, 时寇绥、宁、甘、宣、大等边。”<sup>53</sup>, “Монголжинд найман отогтой, хуучиндаа Хосойд харьяалагдаж байсан, одоо их толгойлогч Алтан Абхайд харьяалагдана. Долоон Түмэн, Уйгур, Үүшин, Баяуд, Уругуд, Хонгирад гэх зургаан отогтой, гурван аймаг нь нийт долоон түмэн цэрэгтэй, бүгд Бортохойд нутагладаг, байнга Сүй, Нин, Гань, Сюаньхуа, Датүн зэргийн хил рүү халддаг.” Хэмээжээ. Анх Монголжин аймгийн Хосой тавнанд харьяалагдаж байсан бол, дараа нь Алтан

<sup>49</sup> Манжийн хуучин данс 满文老档. Сэцэн хааны 6 оны 9 сар. Tokio: 東洋文庫. 1959.

<sup>50</sup> Dūjiāji 杜家驥. <蒙古家谱>增修者博清额之家世及该族<蒙古博尔济吉武氏族谱>、<恩荣奕叶>. 《蒙古史研究》辑刊. 2003.

<sup>51</sup> Chenzūseū 陈组绶. Huanmingjifangditu 皇明职方地图. Боть дунд.

<sup>52</sup> Weihuan 魏焕. Jiubianko 九边考. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. kökeqota: neimengyudašuečubanše. 2006. 246.

<sup>53</sup> Weihuan 魏焕. Jiubianko 九边考. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. kökeqota: neimengyudašuečubanše. 2006. 254.



хаанд харьяалагдсан ба тэдний нутаглаж байх нутаг бол Мони уулын Шар мөрний Бортохой болно.

Тэгвэл XVII зуунаас хойш зохиогдсон Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Урианхайн ноёдын тухай тэмдэглэсэн нь олонтой боловч, тэд нарыг бидний сүүлийн үед судлаачдын тоймлосон ойлголтоор яг Хэнтийн Урианхайн хүн юу, эсвэл Доянь Урианхайн хүн үү гэдгийг тодорхойлон тэмдэглээгүй, бүгдийг нь ерөнхийлөн Урианхай хэмээсэн бий. Орочу шигүшийг Урианхай болон Уругуд аймагтай холбож тэмдэглэсэнтэй үзвэл, Орочу шигүш бол Доянь Урианхайтай холбогдох болно.

### 3. Орочу шигүш ба Доянь Урианхайн хоорондын холбоо

Дээр Уругуд аймгийг тухайн үед Доянь Урианхайн эзэмшиж байсан цар хүрээнд нутаглаж байсныг өгүүлсэн бол, Монголын ихэнх түүхийн сурвалж бичигт Уругуд аймгийн ноён хэмээн тэмдэглэсэн Орочу шигүш нь яг Доянь Урианхайтай ямар холбоотой байхыг доор үргэлжлэн судалж үзье.

“Мин улсын Жэнтунгийн хоёрдугаар оны есдүгээр сарын улаагчин хонин өдөр (正統二年九月丁未 1437 он) -ийн тэмдэглэлд, “敕諭朵颜卫指挥完者帖木儿、朵罗干，头目伯台等曰，往者，尔等犯边，边臣数请出师问罪，朕皆遏之。今后奏尔部属入境剽掠，为我军擒获朵乐帖木儿，械送来京，讯之。始知往岁延安、绥德扰边者亦皆尔众。”<sup>54</sup>, “(Хаан) Доянь харуулын жи хүй Өлзийтөмөр, Дөлгөөн, толгойлогч Бөтэй зэрэгт зарлиг буулгаж хэлсэн нь, өнгөрсөнд та нар хил рүү халдаж, хилийн түшмэд олон удаа цэрэг хөдлөхийг гуйсанд би бүгдийг нь хориглосон. Дараа нь та нарын харьяатууд хил рүү орж дээрэм хийхэд, бидний цэрэгт баригдсан Долонтөмөр нь нийслэлд хүргэж шалгаж асуухад, өнгөрсөн онд Янь-ан, Сүйдэд очиж хил дагуу халдсан нь бүгд та нар болохыг мэдэв...” гэжээ. Мөн Мин улсын үеийн Фан Кунжао (方孔炤)-гийн “Мин чуань бянь люэ жи” 《明全边略记》-д тэмдэглэхдээ, “九年（正統 1444年），兀良哈等虽阳贡，屡寇辽东、延安边境。”<sup>55</sup>, “есдүгээр онд (Жэнтунгийн есдүгээр он, 1444 он), Урианхай зэрэг аймаг илээр алба барьж байсан боловч олон удаа Ляодун, Янь-аны хилийг халдсан.” гэснээс үзвэл, Доянь Урианхай зэрэг аймгууд 1437 оноос өмнө нэгэнт Муни уулын Шар мөрний<sup>56</sup> Бортохойд очиж Мин улсын хил рүү дайралт хийж эхэлсэн байна. Энэ нь голчлон Доянь Урианхай байсан нь харагдана.

<sup>54</sup> Min yingzūng šilu明英宗实录, 34 бүлэг. Жэнтунгийн хоёрдугаар оны есдүгээр сарын улаагчин хонийн өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>55</sup> Fangkūnjo 方孔炤. minčuanbianliueji 明全边略记. 1-бүлэг. 明代蒙古汉籍史料汇编. 第三辑. Kōkeqota: neimengyudašiečubanše. 2006. 5.

<sup>56</sup> Энэхүү Шар мөрнийг Өвөр Монголд Хатан гол гэж нэрлэдэг. Хятадаар Хуанхэ (黄河) гэдэг.

“Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Жэнтунгийн арван нэгдүгээр оны арван нэгдүгээр сар (正統十一年十一月, 1446 он)-ын тэмдэглэлд, “壬申, 命朵颜卫故都指挥使完者帖木儿孙阿古蛮袭职。”<sup>57</sup>, “Хар бичин өдөр, Доянь харуулын хуучин дү жи хүй ши Өлзийтөмөрийн ач Агуман нь тушаалыг залгамжилсан.” 1446 онд Агуман (阿古蛮) өвөг эцэг Өлзийтөмөрийн тушаалын цолыг нь залгамжилсан гэв. “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Жиньтайгийн тавдугаар оны зургадугаар сарын улаан бичин өдөр (景泰五年六月丙申1454 он)-ийн тэмдэглэлд, “朵颜卫都指挥阿尔乞蛮遣哈刺等来朝言, 为瓦刺也先所逼, 徙其部于黄河母纳之地。”<sup>58</sup>, “Доянь харуулын дү жи хүй Арчиман нь Хара зэрэг хүнийг хааны ордонд илгээж, Ойрадын Эсэний дарамт шахалтаас зайлахын тулд харьяат аймгаараа Шар мөрөн, Муни уулын нутагт нүүж очив хэмээн мэдүүлсэн.” хэмээв. Энд “Арчиман”, “Агуман” бол нэг хүн болно. Эдгээр нь 1454 онд Доянь Урианхайн ноён Арчиман нь Доянь Урианхайн харьяатаа дагуулан Муни уул, Бортохой зүг рүү нүүсэн гэдгийг илэрхийлж байна. 1470 онд Доянь Урианхайн Дү дү Дөлгөөний хүү Тогооч нь Орочу шигүшийн хамт Шар мөрний Бортохойд байсан<sup>59</sup>. Мөн “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Чэнхуагийн арван нэгдүгээр оны аравдугаар сарын хөхөгчин туулай өдөр (成化十一年十月乙卯, 1475 он)-ийн тэмдэглэлд, “近闻北虏满都鲁僭立名号, 吞并别部, 驱散朵颜三卫, 设或被其逼从, 为之向导, 遣患非小。”<sup>60</sup>, “Ойрд умард дайсан Мандуул хаан сууснаа зарлаж, бусад аймгуудыг оруулан, Доянь Гурван харуулыг хөөн, эсвэл тэд нарыг харьяандаа оруулан замч болгож, их аюул дагуулах нь болзошгүй юм” хэмээжээ. Дээрх “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн тэмдэглэлээс үзэхэд, Доянь Урианхай нь 1437 оны өмнөөс 1475 он хүртэл удаан хугацааны туршид Муни уул, Бортохойд орж гардаг байжээ.

Мин улсын түүхийн сурвалж бичигт Орочу шигүшийг 1449 оноос эхлэн Шар мөрний Бортохойд байсан хэмээн тэмдэглэсэн билээ<sup>61</sup>. Тяньшүнгийн жилүүдэд (天顺1457-1464) Орочу шигүш мөн Бортохойд байсан бол, 1465 оноос эхлэн Мулихай, Бэгэрсэн, Мандуул зэрэг хүрэлцэн ирсэн<sup>62</sup> бөгөөд тухайн үед Бортохойд Монголын олон

<sup>57</sup> Min yingzǔng šilu 明英宗实录, 147 бүлэг. Жэнтунгийн арван нэгдүгээр оны арван нэгдүгээр сарын хар бичин өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>58</sup> Min daizǔng šilu 明代宗实录, 242 бүлэг. Жинтайгийн тавдугаар оны зургадугаар сарын улаан бичин өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>59</sup> Min šianzǔng šilu 明宪宗实录, 79 бүлэг. Чэнхуагийн зургадугаар оны тавдугаар сар. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>60</sup> Min šianzǔng šilu 明宪宗实录, 146 бүлэг. Чэнхуагийн арван нэгдүгээр оны аравдугаар сарын хөхөгчин туулай өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>61</sup> Mawenšen 马文升. šijenšhičenji 西征石城记. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 115.

<sup>62</sup> Fangkūnjo 方孔炤. minčuanbianliueji 明全边略记. 4-бүлэг. 明代蒙古汉籍史料汇编. 第三辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 149.

аймаг, отгийн ноёд цуглаж байсан харагдана. Баянмөнх Болху бол Орочу шигүшээр хамгаалуулж байсан болохоор, хамтдаа Бортохойд байв. Баянмөнх яваандаа хүч чадал нь бэхжиж, Монголын олон аймаг отгийн дунд гол удирдагчийн нэг нь болсон билээ. “八年（成化 1472年）正月，马文升奏，虏酋乜加思兰纠合阿罗出部落渡河犯边，已及岁余，虽互相仇杀，分为二路。”<sup>63</sup>，“Наймдугаар оны（Чэнхуагийн наймдугаар он, 1472 он）цагаан сард, Ма Вэншэний айлтгаснаар, дайсны толгойлогч Бэгэрсэн нь Орочутой нийлэн гол гаглан хил рүү дайралт хийв. Жилийн дараа, тэд хоорондоо дайсагнаж хоёр бүлэг хуваагдав.” хэмээн Мин улсын түүхийн сурвалж бичгийн тэмдэглэснээс үзэхэд, Орочу шигүш наад зах нь 1472 он хүртэл Бортохойд байжээ.

Дээр дурдсан тэмдэглүүдээс үзэхэд Доянь Урианхай нь 1437 оноос өмнө эхлэн Муни уулын Бортохойд орж гардаг болсон бөгөөд 1475 оны үед бүрмөсөн гараад Доянь Урианхайн өөрийн нутагт буцсан бололтой. Орочу шигүшийн Муни уулын Бортохойд орж эхэлсэн тэмдэглэл нь 1449 оноос 1472 он хүртэл болно. Өөрөөр хэлбэл Орочу шигүшийн Муни уулын Бортохойд очих он жилүүд нь Доянь Урианхайн Бортохойд орж гарах цаг үеийн дотор нь байв. Мин улсын түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр 1465 оноос өмнө Бортохойд орж гарах Монгол аймаг бол зөвхөн Гурван харуулын аймгууд болон Орочу шигүш байжээ. Үүнд Мин улсын талын түүхийн сурвалж бичгүүдийн дунд тэд нарын хамт Бортохойд байсан тухай мөн тэмдэглэсэн байна, “其冬（成化二年 1466年），阿罗出纠兀良哈寇延、庆，于是抚宁侯永为平虏将军，都御史王越督师，往延绥御虏。”<sup>64</sup>，“Тэр өвөл（Чэнхуагийн хоёрдугаар он, 1466 он），Алөчу Урианхайн хамт Янь, Чинь рүү халдав, тэгээд фүнин хэү Юүн дайсныг дарах Жанжин болов, дэү юү ши Ван Юүэ нь дайснаас хамгаалахаар цэргээ дагуулан Янь Сүйд очсон.” Энд Янь, Чинь бол Бортохойн зүгийн Цагаан хэрэмнээс урд Мин улсын Яньан（延安）, Чиньянь（庆阳）болно, Янь Сүй бол Яньан, Сүйдэ（绥德）болно. “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Чэнхуагийн зургадугаар оны тавдугаар сарын（成化六年五月, 1470 он）тэмдэглэлээр, “乙酉，镇守蓟州太监龚荣奏，福余卫平章遣赤劳温等至大喜峰口报，伯革赞太师、孛罗乃王、孛罗丞相三人率万骑东行，又斡失帖木儿率四万骑驻牧西北，阿罗出小石王率万骑同朵颜卫都督朵罗干男脱火赤二百骑在西。”<sup>65</sup>，“Хөхөгчин тахиа өдөр, Жижэүг сахих тайган Гүн Рүний айлтгаснаар,

<sup>63</sup> šiurijiu 徐日久. wubianbianze 五边典则. 5-бүлэг. 明代蒙古汉籍史料汇编. 第五辑. Kökeqota: neimengyudašüecubānše. 2006. 400.

<sup>64</sup> Ye šiango 叶向高. siyiko 四夷考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kökeqota: neimengyudašüecubānše. 2006. 508.

<sup>65</sup> Min šianzüng šilu 明宪宗实录, 79 бүлэг. Чэнхуагийн зургадугаар оны тавдугаар сарын хөхөгчин тахиа өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

Фууюй харуулын пин жань Чулуун зэргийг Баясгалан хадат хаалгад (喜峰口) илгээн мэдүүлсэн нь, Бэгэрсэн тайш, Борной ван, Болай чинсан гурвуул 10,000 морьт цэрэг дагуулан зүүн зүг хөдлөн, Очтөмөр 40,000 морьт цэрэг дагуулан баруун хойд талд нутаглан, Орочу шигүш 10,000 морьт цэрэг дагуулан Доянь харуулын Дү дү Дөлгөөний хөвгүүн Тогоочийн 200 морьт цэрэгтэй хамт баруун зүгт байна.” хэмээв. Эдгээр түүхийн сурвалж бичигт Орочу шигүш 1449 оноос хойш Доянь Урианхайтай хамт Муни уулын Бортохойд байсныг илэрхийлсэн. Дээр өгүүлснээр, Уругуд аймгийн нутаглах газар нь Доянь Урианхайн харьяат нутагт байсныг тодорхойлсон бол, түүний ноён Орочу шигүш нь Доянь Урианхайтай хамт Муни уулын Бортохойд орч гардаг байсан тэмдэглэлээс үзвэл, Орочу шигүш бол Доянь Урианхайн нэгэн ноён болох нь эргэлзээгүй юм.

Тэгвэл 1470 онд Орочу шигүш 10,000 морьт цэрэгтэйгээ Доянь Урианхайн тэргүүн ноён Дөлгөөний хөвгүүн Тогоочтой хамт баруун зүгт байгаа гэсэн Хятадын Мин улсын талын тэмдэглэснээс үзвэл, тухайн үед Монголын эл аймгийн дунд томоохон ноёд гэж алдаршсан Бэгэрсэн тайш, Борной ван, Болай тайш гурвуулаа нийлээд Орочу шигүштэй тэнцэх 10,000 морьт цэргийн хүчтэй байж, Орочу шигүш тухайн үеийн Монголын олон аймаг, отгийн дунд маш хүчирхэг удирдагчийн нэг нь байсан болно. Хэрвээ зөвхөн Монголын түүхийн сурвалж бичгүүдийн тэмдэглэснээр, Орочу шигүш нь зөвхөн Уругуд аймгийн ноён гэвэл, Уругуд аймаг нь тухайн үеийн Монголын олон аймаг отгийн дунд нэгэн мянган буюу нэг отогтой тэнцэх нэгж бүлэг байх бөгөөд 10,000 морьт цэргийн хүчтэй болох боломжгүй юм. Үүнээс үзэхэд Орочу шигүш зөвхөн Уругуд аймгийн тэргүүн ноён бус харин мөн Доянь Урианхайн гол ноёдын нэг нь бөгөөд тухайн үед их хааны шигүш хэмээх тушаалын цол авсан түшмэд болно. Эргээд “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Жиньтайгийн тавдугаар оны зургадугаар сарын улаан бичин өдрийн тэмдэглэлээс үзэхэд, “Доянь харуулын Дү жи хүй Арчиман нь Хара зэрэг хүнийг Мин улсын хааны ордонд илгээж, Ойрадын Эсэний дарамт шахалтаас зайлахын тул харьяат аймгаараа Шар мөрнөөс ойрхон Муни нутагт нүүн очив хэмээн мэдүүлэв”<sup>66</sup> хэмээх тэмдэглэлээс үзэхэд, Доянь Урианхайн ноён Арчиман нь Орочу шигүштэй нэгэн цаг үед Ойрадын Эсэн тайшийн аюулаас зайлахын төлөө Бортохойд нүүж очсон байна. Мин улсын түүхийн сурвалж бичигт Мин улсын Тяньшүн (天顺)-гийн хоёрдугаар оны арван нэгдүгээр сард (1458 он), Мин улсын төрөөс Арчиманд Доянь харуулын Дү дү чьянь ши (都督金事) хэмээх цол

<sup>66</sup> Min daizūng šilu 明代宗实录, 242 бүлэг. Жинтайгийн тавдугаар оны зургадугаар сар. Taiwan: 中央研究院历史语言研究所.

олгож өгсөн хэмээн тэмдэглэсэн<sup>67</sup>.

Хэдийгээр Арчиман Доянь Урианхайн өөрийн харьяатаа дагуулан Бортохойд орж гардаг байсан нь үнэн түүх мөн боловч, Хятадын Мин улсын буюу Монголын түүхийн сурвалж бичгүүдэд түүнийг Бортохойд байхад ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байсан тухай огтхон ч дурдсангүй, харин зөвхөн Орочу шигүшийн тухай тэмдэглэж ирсэн юм. Дээр дурдсан Мин улсын талын түүхийн сурвалж бичгүүдэд Бортохойн Мин улсын хилийн дагуу нутагт Орочу шигүшийн тухай тэмдэглэл их байсан ч Орочу шигүшийн аймаг отгийн гарлын тухайд зөвхөн “Болайгийн доорх их толгойлогч” хэмээснээс өөр тодорхой тэмдэглэл байхгүй, мөн Орочу шигүшийн Баянмөнх Болху жонон хоорондын харьцааг ч мэдэхгүй бололтой. Энэ нь Мин улсын талын түүхийн сурвалж бичигт Монголын тухай тэмдэглэлийн ихэнх нь монголчуудаас дамжин мэдээ авснаас шалтгаалан дутуу бөгөөд андуурал их байснаас болсон юм.

Дээр дурдсанаар, Хятадын түүхийн сурвалж бичигт Орочу шигүшийг 1449 оноос эхлэн Шар мөрний Бортохойд орж Хятадын хил хязгаар руу байнга дайрдаг болов<sup>68</sup>. 1454 онд Доянь Урианхайн ахлагч Арчиман Мин улстай хилийн худалдаа хийхийн төлөө хүн зарж Мин улсад Шар мөрнөөс ойрхон Муни уулын нутаг руу нүүн явахыг мэдэгдэв<sup>69</sup>. Тэгвэл “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Чэнхуагийн хоёрдугаар оны өвлийн аравдугаар сарын улаан луу өдөр (成化二年冬十月丙辰, 1466 он)-ийн тэмдэглэлээс үзэхэд, “监督军务太监斐当等奏, 今年九月, 谍报贼首阿老出等拥众入边抢掠, 毛里海率众袭其老营, 尽掠其人口孳畜。阿老出同其子及头目十余人俱遁去。”<sup>70</sup>, “Цэргийн хэргийг хянах тайган Фэй Дан зэргийн айлтгаснаар, энэ оны есдүгээр сард хулгайчдын толгойлогч Алочу (Орочу шигүш) цэргээ дагуулан хил рүү орж ирээд дээрэмдэв. Мулихай цэргээ дагуулан түүний ар гэрийг нь довтолж бүх хүн ам, мал сүргийг нь авсан. Алочу хөвгүүдийн хамт арваад хүнтэйгээ зайлан явав.” хэмээсэн мэдээ байна. Тухайн жилийн есдүгээр сард, Орочу шигүшийг Мин улсын хил рүү довтлохоор очиход, Мулихай ван түүний ар гэр рүү нь дайрч, Орочу шигүш цөөн хүнтэйгээ зайлан явсан гэжээ. “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Доянь Урианхайн зүгийн тэмдэглэлээс 1454

<sup>67</sup> Min yinzüng šilu 明英宗实录, 297 бүлэг. Тианшүнгийн хоёрдугаар оны арван нэгдүгээр сар. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>68</sup> Wüyünbilige 乌云毕力格. <金轮千福>所载扎鲁特蒙古. 西北民族大学学报. 2010. 6; Гантулга, Ц.Алтайн Урианхайчууд, Улаанбаатар хот, 2014. т.71.

<sup>69</sup> Min daizüng šilu明代宗实录, 242 бүлэг. Жинтайгийн тавдугаар оны зургадугаар сарын улаан бичин өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>70</sup> Min šianzüng šilu明宪宗实录, 35 бүлэг. Чэнхуагийн хоёрдугаар оны өвлийн арвандугаар сарын улаан луу өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

оноос хойш олон жилийн туршид Арчиманы тухай тэмдэглэл байхгүй болоод, 1466 оны 9 дүгээр сард Орочу шигүшийг Мулихайд хөөгдсөний дараа, 1467 оны цагаан сар, 1469 оны 11 дүгээр сард, Арчиман хоёр удаа хүн зарж Мин улсад очиж бараа солилцох зэрэг үйл ажиллагаа хийсэн<sup>71</sup> хэмээх тэмдэглэл харагдана. Тэгвэл 1466 оны 10 дугаар сараас 1469 оны өвөл хүртэл 3 жилийн турш Бортохойн зүгийн хил дагуу мэдээлэлд Орочу шигүшийн тухай тэмдэглэл байхгүй болж байна.

“Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Чэнхуагийн зургадугаар оны гуравдугаар сарын шар нохой өдөр (成化六年三月戊戌1470 он)-ийн тэмдэглэлээр, “兵部奏, 迤北虏酋阿罗出诱朵颜三卫自去冬乘冰渡河, 寇掠延庆等处, 今虽东归, 而阿罗出人马尚在河套潜住。”<sup>72</sup>, “Цэргийн яамны айлтгаснаар, өнгөрсөн өвөл хойд зүгийн дайсны толгойлогч Алөчү (Орочу шигүш) Доянь гурван харуулыг дагуулан гол (Шар мөрөн) гатлан Янь, Чинь зэрэг газрыг дээрэмдэв. (Гурван харуулын цэрэг) одоо зүүн зүг буцсан боловч, Алөчүгийн цэрэг мөн Бортохойд нуугдан байсаар” хэмээжээ. Орочу шигүш 1469 оны өвөл дахин Бортохойд орж Мин улсын хил рүү довтолсон. Орочу шигүш 1469 оны өвлөөс 1472 он хүртэл Бортохойд байгаад 1472 оноос хойш Мин улсын талын түүхийн сурвалж бичигт түүний тухай тэмдэглэл байхгүй болсон байна.

“Мин улсын үнэн тэмдэглэл”-д 1469 оны өвлөөс Доянь Урианхайн ноён Арчиманы тухай тэмдэглэл байхгүй болж ойролцоогоор гурван жил болсны дараа, 1472 оны 12 дугаар сард, Доянь Урианхайн Дү дү Арчиман нь Чин тайж зэрэг хүнийг зарж Мин улсад бараа солилцохоор очсон хэмээн тэмдэглэжээ<sup>73</sup>. Мөн 1469 онд Тогооч, Орочу шигүштэй хамт Бортохойд очсон бол, Тогооч мөн 1473 оны үед Доянь Урианхайн нутагтаа буцаж Мин улс руу элч зарсныг “Мин улсын үнэн тэмдэглэл”-д тэмдэглэжээ<sup>74</sup>. Дээрх түүхийн сурвалж бичгүүдийн тэмдэглэснээс үзэхэд, Орочу шигүшийн тухай Бортохойн зүгийн тэмдэглэлд тэмдэглэх үед, Доянь Урианхайн зүгийн хил дагуу мэдээлэлд Арчиманы тухай тэмдэглэл харагдахгүй болно. Энэ нь Орочу шигүш болон Арчиман бол нэг хүн болохыг улмаар илэрхийлж байна. Мин улсын талын түүхийн сурвалж

<sup>71</sup> Min shianzung shilu明宪宗实录, 38 бүлэг. Чэнхуагийн гуравдугаар оны цагаан сарын хөхэгчин тахиа өдөр. 73 бүлэг. Чэнхуагийн гавдугаар оны арван нэгдүгээр сарын хөх бичин өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>72</sup> Min shianzung shilu明宪宗实录, 77 бүлэг. Чэнхуагийн зургадугаар оны гуравдугаар сарын шар нохой өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>73</sup> Min shianzung shilu明宪宗实录, 111 бүлэг. Чэнхуагийн наймдугаар оны арван хоёрдугаар сарын цагаан луу өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>74</sup> Min shianzung shilu明宪宗实录, 124 бүлэг. Чэнхуагийн аравдугаар оны хаврын цагаан сарын цагаагчин гахай өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.



бичгүүдийн тэмдэглэлээс үзэхэд, хэрвээ Арчиман болон Орочу шигүш нь хоёр хүн байсан бол, Арчиман болон Орочу шигүш хоёр зэрэг Бортохойд орж гардаг байсан болно. Гэтэл Мин улсын түүхийн сурвалж бичигт Бортохойн зүгийн тухай тэмдэглэл зөвхөн Орочу шигүшийн тухай тэмдэглэсэн юм. Эсрэгээр Монголын түүхийн сурвалж бичигт Доянь Урианхайн ноён Дөлгөөний хүү Тогоочийг Орочу шигүштэй Бортохойд очсон мөртлөө, Доянь Урианхайн гол ноёдын нэг Арчиманы тухай тэмдэглэл огт байхгүй юм.


Өмнөх судлаачид Хятадын Мин улсын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Гурван харуул нь Мин улсын захиргаанд орсон гэдэг тэмдэглэлийн нөлөөгөөр, Доянь Урианхайг Монголын их хааны төрийн захиргаанаас гарсан хэмээн ойлгож байв. Судлаач Дарьжавын өгүүлснээр, “我们说兀良哈三卫只是名义上藩属明廷，实际并不受明朝的管辖，这是因为有明一代三卫（岭南蒙古或山阳万户）几乎都受北元大汗的控制，成为其属部之一，没有一个北元大汗会放弃对岭南蒙古的管辖权。”<sup>75</sup>, “Урианхай гурван харуулыг зөвхөн нэрэн дээрээ Мин улсын хаанд харьяалагддаг, үнэн хэрэг дээр Мин улсад захирагдахгүй гэж хэлэх шалтгаан бол Мин улсын үеийн Гурван харуул (мөн “Хянган нуруунаас өмнөх Монгол” буюу “Өлөг түмэн” гэдэг) нь бараг бүгд Умард Юань улсын их хаанд захирагддаг, мөн түүний нэгэн харьяат аймаг болно. Умард Юань улсын их хаан бүгд Хянган нуруунаас өмнөх Монголчуудыг захиргааны гадуур орхихыг хүсэхгүй байсан юм” хэмээгээд, “明人常说，三卫‘名曰效顺，实图赏赉’，实质上三卫与明廷的隶属关系主要是一种通贡贸易的形式。经济上的依赖，使三卫尽可能保持与明朝的和平相处关系，这是三卫与明朝关系的实质。”<sup>76</sup>

“Гурван харуул нь нэрэн дээр зарлигийг дагана гэдэг ч, үнэн хэрэг дээр зөвхөн шагнал хүссэн юм гэж Мин улсын хүн үргэлж ярьдаг. Үнэн байдал дээр Гурван харуул болон Мин улсын хоорондын харьцаа бол зөвхөн алба барьж арилжаа хийх хэлбэрийн төдий юм. Эдийн засгийн хараат байдлаас болж Гурван харуул нь Мин улстай чадах чинээгээрээ энх тайван байдлыг үргэлжлүүлэхийг хичээж байсан, энэ бол Гурван харуул болон Мин улсын хоорондын үнэн бодит байдал болно” гэжээ.

<sup>75</sup> Dalijabū 达力扎布. minčingmenggüsilünṡao 明清蒙古史论稿. Beijing: mingzucubanše 民族出版社. 2004. 204.

<sup>76</sup> Dalijabū 达力扎布. minčingmenggüsilünṡao 明清蒙古史论稿. Beijing: mingzucubanše 民族出版社. 2004. 203.





XV-XVI зууны үеийн Урианхай болон Уругуд аймаг

Доянь Урианхай бол Мин улстай арилжаа наймаа хийхийн төлөө Мин улсын өгсөн цол тушаалыг хүлээн авч байсан ч үнэн бодит байдал дээр тэд Монголын их хааны төрийг ямагт дагадаг байв. Тиймээс Монголын тал Доянь Урианхайн тухай маш сайн мэддэг байх нь тодорхой. Гэтэл Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Доянь Урианхайн ноён Дөлгөөн болон түүний хүү Тогооч, Мэнд дарханы (Бас

Мэнд өрлөг, Мэнд ван гэдэг) тухай тэмдэглэсэн<sup>77</sup> мөртлөө Мин улсын талын тэмдэглэсэн Арчиман болон түүний хүү Хуадан гэсэн нэртэй ноёдын тухай тэмдэглэл харагдахгүй байлаа.

#### 4. Монголын их хаантай тогтоосон ургийн барилдлага

Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Урианхайн ноён Орочу шигүш болон Хутуг шигүш хоёрыг Баянмөнх жонон болон Батмөнх Даян хаантай ургийн холбоо барьсан гэж тэмдэглэсэн бол, Хятадын Мин улсын түүхийн сурвалж бичигт бол Доянь Урианхайн ноён Арчиман болон Хуадан хоёр мөн Монголын их хаантай ургийн холбоо барьсан тухай тэмдэглэжээ. “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Хунжигийн арван долдугаар оны зургадугаар сарын цагагчин могой өдрийн тэмдэглэлд (弘治十七年辛巳, 1504 он) Доянь Урианхайн ноёд Монголын их хаантай барьсан ургийн холбооны талаар “朵颜卫酋阿尔乞蛮率众三百人, 往北虏通和小王子, 与一女寄养, 似有诱引入寇之跡···”<sup>78</sup>, “Доянь харуулын тэргүүн Арчиман нь гурван зуун хүн дагуулан хойд дайсан Сяованзытай найрамдаж, нэгэн охиноо өргүүлж өгч, манайх руу дайруулах шинжтэй” хэмээжээ. 1504 онд Доянь Урианхайн ноён Арчиман нэгэн охиноо хойд зүгийн Сяованзыд (Монголын их хаан, тухайн үед Мин улсын зүгээс Монголын их хааныг “Бага хан хүү” гэж басамжилж нэрлэж байв) хүргэж өгсөн хэмээн тэмдэглэсэн нь, Монголын түүхийн сурвалж бичгүүдийн Орочу шигүш хүү Худуг шигүшийн охин Жимсгэнийг Батмөнх Даян хаанд бага хатан болгон хүргэж өгсөн явдлыг хэлжээ. Мөн “Мин улсын үнэн тэмдэглэл”-ийн Хунжигийн арван наймдугаар оны цагаан сарын (弘治十八年正月, 1505 он) тэмдэглэлд, “庚子, 朵颜卫都督阿尔乞蛮遣使来贡, 且言迤北小王子欲妻以女, 不从, 数被仇杀, 终不改图。镇守蓟州太监陈荣以闻。下兵部议, 阿尔乞蛮自陈为国效忠, 不与北虏和亲。其情伪虽不可知, 然不可不量加嘉奖, 以坚其内附之心。命降敕奖谕之。”<sup>79</sup>, “Цагаан хулгана өдөр, Доянь харуулын Дү дү Арчиман элч зарж алба барихаар

<sup>77</sup> Лувсанданзан, *Алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011 он. т.745. 162а. 162б. 729. 147а. 741. 159а. 750. 168а. 751. 168б. 169б; *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011. т.287. 71б. 288. 72а. 274. 52а. 285. 68а. 288. 79б. 80а. 80б; Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011, т.485. 63г.

<sup>78</sup> *Min šiozūng šilu* 明孝宗实录, 213 бүлэг. Хүнжигийн арван долдугаар оны зургадугаар сарын цагагчин могой өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>79</sup> *Min šiozūng šilu* 明孝宗实录, 220 бүлэг. Хүнжигийн арван наймдугаар оны цагаан сар. Taiwan: 中央研究院历史语言研究所.

ирэхдээ мэдүүлснээр, хойд зүгийн Сяованзы охиноо өгнө гэхэд, зөвшөөрөөгүйгээс болж олон удаа дайтсан, санаа нь ер өөрчлөхгүй байна. Жижоуг сахих тайган Чэн Рүн энэхүү мэдээг дамжуулав. Цэргийн яаманд зөвлөлдөхийг тушаасан нь, Арчиман өөрөө хойд зүгийн дайсантай ургийн холбоо барихгүйгээр төрд үнэнчээр зүтгэнэ хэмээн айлтгасан. Түүний үнэн худлыг мэдэхгүй боловч, түүнийг манайх руу хандуулах санааг бэхжүүлэхийн төлөө урамшуулж шагнахгүй бол болохгүй. Даруй шагнахыг тушаав”, мөн “是时，把儿孙与小王子婚，屡诱虏入寇。”<sup>80</sup>, “Тухайн үед Багсун Сяованзытэй ургийн холбоо барьж, удаа дараа дайсныг дагуулан манай хилээр нэвтрэн оров” хэмээжээ. 1505 онд Батмөнх Даян хаан охиноо Доянь Урианхайн Арчиманы хүү Хуаданы дэд хүү Багсунд хатан болгон өгсөн билээ.

“Асрагч нэртийн түүх” болон “Шар тууж”-д тэмдэглэсэнээр, Батмөнх Даян хааны Жимсгэн хатнаас төрсөн хоёрдугаар хүү Гэрсэнз нь эм хар тахиа жилд төрсөн хэмээсэн нь 1513 он бөгөөд<sup>81</sup>, энэ нь Арчиман ач охиноо Батмөнх Даян хаанд хатан болгож өгсөн он жилтэй ерөнхийдөө таарч байгаа юм.

“Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д Монголын түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Батмөнх Даян хааны Мандухай сэцэн хатнаас төрсөн ганц охин Төрөлт гүнж<sup>82</sup> (бас Гэгээн гүнж<sup>83</sup> гэдэг)-ийг Жарууд аймгийн Багсун тавнанд хатан болгон өгсөн тухайд, Хурц үзэхдээ, энэхүү Багсун нь Доянь Урианхайн ноён Хуаданы хүү Багсун мөн хэмээсэн бол<sup>84</sup>, харин Оюунбилэг үзэхдээ, энэхүү Багсун нь Доянь Урианхайн Хуаданы хүү бус хэмээжээ<sup>85</sup>. Дээр Мин улсын талын түүхийн сурвалж бичгүүдийн тэмдэглэл ба Монголын түүхийн сурвалж бичиг “Алтан хүрдэн мянган хэгээст” болон “Болор эрих”, “Монголын боржигид овгийн түүх”-д тэмдэглэснийг хянахад<sup>86</sup>, Батмөнх Даян хааны Мандухай сэцэн хатнаас төрсөн ганц охиныг хатан болгон авсан хүн бол Урианхайн Багсун гэж тэмдэглэсэн ба үүнээс үзэхэд Багсун бол Доянь Урианхайн Хуаданы хүү мөн болох нь баталгаатай юм. Үүнээс гадна, “Мин

<sup>80</sup> Ye šiango 叶向高. siyiko 四夷考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kōkeqota: neimengyudašüēcubanše. 2006. 487.

<sup>81</sup> Жамба, *Асрагч нэртийн түүх*. Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор Д.Заяабаатар, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011. т.255-256. 47b-48a.

<sup>82</sup> Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн Ж.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011, т.488. 66г 08.

<sup>83</sup> Darma, altan hürdün mingyan hegesütü, Coij hinaba, öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. т.202.

<sup>84</sup> Hüriča 胡日查. 有关朵颜卫者勒蔑家族史实. neimengyūšehüikešiuе 内蒙古社会科学. 2000. 1.

<sup>85</sup> Wüyünbilige 乌云毕力格. 关于朵颜兀良哈人的若干问题. 《蒙古史研究》第七辑. Kōkeqote. 2013.

<sup>86</sup> Darma, altan hürdün mingyan hegesütü, Coij hinaba, öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. 128; Rašipungčuy, bolor erihe, öbör Mongγol-un heblel-ün horiy-a. 2000. 366. 罗密《蒙古博尔济忒氏族谱》. 内蒙古大学出版社. 2014年. 149.

улсын үнэн тэмдэглэл”-ийн Жяжиньгийн хорьдугаар оны есдүгээр сарын хөх луу өдөр (嘉靖二十年九月甲辰, 1540 он)-ийн тэмдэглэлд, “革兰台骁勇绝伦, 今虽通贡, 乃私与北虏和亲, 广招达子数万, 沿边抢掠。”<sup>87</sup>, “Гэрэлтэй бол эрэлхэг баатарлаг, одоо алба барьдаг боловч мөн хойд зүгийн дайсантай нууцаар ургийн холбоо тогтоож хэдэн түмэн цэрэг цуглуулан хил дагуу дээрэм хийдэг” хэмээн тэмдэглэсэн бий. Энд дурдсан Гэрэлтэй бол Хуаданг залгамжилсан Доянь Урианхайн тэргүүн ноён юм. Бас Халх түмнийг эзэлсэн Гэрсэнзийн хоёр хатан нь “Асрагч нэртгийн түүх” болон “Шар тууж”-д тэмдэглэсэнээр нэг нь Үжээд буюу Урианхайн Мэндийн охин, нөгөө нь мөн Үжээдийн Мөнгүйчийн охин билээ<sup>88</sup>. “Эрдэнэ тунамал нэрт судар оршив” зэрэг Монголын түүхийн сурвалж бичгүүдэд Гурван харуулыг “Үжээд улс”<sup>89</sup>, “Зургаан мянган Үжээд” хэмээн нэрлэдэг<sup>90</sup>. Эдгээр тэмдэглэлээс үзэхэд, Арчиман, Хуадан, Багсун, Гэрэлтэй зэрэг Доянь Урианхайн ноёд Монголын их хаан болон алтан ургийн бусад ноёдтой ургийн холбоо барьж ирсэн явдал нь, Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэж ирсэн Орочу шигүшээс эхлэн Хутуг шигүшийг дамжин Урианхайтай үргэлжилж ирсэн ургийн холбоо болно. Энэхүү Монголын их хаан ба Доянь Урианхайн хооронд үргэлжилсэн ургийн холбоог үзэхэд, Чингис хаанаас хойших Монголын их хааны удам Монголын эл аймаг отгийн дунд Хонгирад, Ойрад зэрэг аймаг отгийн ноёдын угсаатай тогтмол ургийн холбоо барьж ирсэн жишээтэй нэгэн адил болно. “Юань улсын судар”-т, “丁酉, 赐钱二十万缗, 有旨: ‘弘吉刺氏生女世以为后, 生男世尚公主...’”<sup>91</sup> “Улагчин тахиа жил, 200,000 хэлхээ зоосоор шагнаж тушаав, Хонгирад овгийнхон охин төрвөөс үүрд хатан болох, хөвгүүн төрвөөс үүрд гүнжээ өгнө.....” хэмээн тэмдэглэсэн. Хубилай хаанаас хойш Монголын их хаан хэдэн үеэр Хонгирадын Дай Сэцэний хойч үеийн охиноос хатан болгон авч, мөн хааны гүнжийг тэдний хөвгүүдэд хатан болгон өгч байсан юм.

Доянь Урианхайн ноёдын Монголын их хаантай барьсан ургийн холбооны тухайд А.Очир “Батмөнх Даян хааны үед дээрх Урианхай нар (Доянь Урианхайг

<sup>87</sup> Min šizüing šilu 明世宗实录, 253 бүлэг. Жиажиньгийн хорьдугаар оны есдүгээр сарын хөх луу өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>88</sup> Жамба, *Асрагч нэртгийн түүх*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор Д.Заяабаатар, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011. т.255-256. 47b-48a; *Шар тууж* 《蒙古黄史》. Өлзийт орчуулан тайлбарлав 乌力吉图译注. Kökeqot: neimengyudašiuеcubанše 内蒙古大学出版社. 2014. 33.

<sup>89</sup> *Эрдэнэ тунамал нэрт судар оршив* 阿拉坦汗传, Жүрүнга орчуулан тайлбарлав 朱荣嘎译注. Kökeqot: neimengyudašiuеcubанše 内蒙古大学出版社. 2014. 256-257. 9a-9b.

<sup>90</sup> Саган Сэцэн, *Хаадын үндэсний Эрдэнийн товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар хот, 2011. т.477. 54v 08.

<sup>91</sup> Song Lian 宋濂, Yuanshi 元史. Боть 118, Beijing: zhonghuashuju. 1976. 1923.

заав) түүнд захирагдаж байв. Тэд мөн Монголын алтан ургийн угсааныхантай байн байн ураг холбож, ойр дотно харилцаар байж...”<sup>92</sup> хэмээн өгүүлсэн бол Дарьжав “朵颜卫首领世代与大汗联姻，成为塔布囊。”<sup>93</sup>, “Доянь харуулын ноёд нар үе дараалан их хаантай ургийн холбоо барьж тавнан болов.”, “正德二年 (1507年) 阿尔乞蛮子花当袭职，花当及其子孙把儿孙、革兰台世与小王子联姻，称雄三卫，正如《辽东志》所说，此时三卫之中朵颜最强。”<sup>94</sup>, “ Жэндэгийн хоёрдугаар онд (1507 он), Арчиманы хөвгүүн Хуадан түүний тушаалыг залгамжлав. Хуадан болон түүний үр ач Багсун, Гэрэлтэй нь Сяованзытай ургийн холбоо барьж, Гурван харуулын дунд хүчирхэг болов. Яг “Ляо дун жи”-д тэмдэглэсэнээр, энэ үед Гурван харуулын дунд Доянь нь хамгийн хүчирхэг байсан болно.” хэмээжээ. Доянь Урианхайгаас Монголын их хаантай барьсан энэхүү ургийн холбоо нь нөгөө талаар Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэж ирсэн Орочу шигүш болон Хутуг шигүш хоёр бол Хятадын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Доянь Урианхайн Арчиман болон Хуадан мөн болохыг нотолж байна.

“Лу лун сай люэ” 《卢龙塞略》-д тэмдэглэсэнээр, Түмэн хаан охиноо Хутуг шигүшийн ач Даха (打哈)-гийн хүү Матаха (马塔哈)-д хатан болгож өгсөн<sup>95</sup>. Бас “Жи мэн као” 《蓟门考》 -д тэмдэглэсэнээр, Хутуг шигүшийн хойч үеийн Онголчийн охин (Чоман (炒蛮)-ы дүү) Боди Алаг хааны дүү Нэмигийн хүү Бүйма (悲马)-д хатан болсон гэжээ<sup>96</sup>.

Орочу шигүш болон Хутуг шигүшийн хойч үеийнх Их хаантай ургийн холбоо барьснаас гадна, бас Барсболдын хойч үеийнх бөгөөд Гэрсэнз болон Гэрсэнзийн хойч үеийнхтэй өргөн хүрээний ургийн холбоо тогтоожээ. Хятадын Мин улсын үеийн “Лу лун сай люэ”, “Жи мэн као” болон “Бэй лу жи люэ” 《北虏纪略》-д тэмдэглэсэнээр, Барсболдын дөрөвдүгээр хүү Баясхал (老把都，把都儿) нь Хутуг шигүшийн хойч үеийн Төрэй (脱力)-гийн охин Мөнхчин (猛可充)-г хатан болгож авсан<sup>97</sup>. Алтан хааны ахмад хүү Сэнгэдүүрэн (黄台吉，辛爱) нь Хутуг шигүшийн

<sup>92</sup> Очир, А., Урианхай нарын угсаа-түүхийн асуудал, *Түүхийн судлал*, XXXII, 2000, т.24.

<sup>93</sup> Daljabu 达力扎布. mincingmenggüsilünᠶao 明清蒙古史论稿. Beijing: mingzucubanše 民族出版社. 2004. 207.

<sup>94</sup> Daljabu 达力扎布. mincingmenggüsilünᠶao 明清蒙古史论稿. Beijing: mingzucubanše 民族出版社. 2004. 198-199.

<sup>95</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг. kobu 考部. gungciuko 贡酋考.

<sup>96</sup> Mi wančun 米万春. jimenko 蓟门考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 554-555.

<sup>97</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг. kobu 考部. gungciuko 贡酋考. Mi wančun 米万春. jimenko 蓟门考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 554-555.



хойч үеийн Баяндалай (伯彦达赖, 孛彦达来)-гийн охин, Дүнхур (董狐狸)-ын охин, Буянтөгс (伯彦帖忽思)-ийн охин гэх гурав хүнийг хатан болгож авсан<sup>98</sup>. Мөн Сэнгэдүүрэн, Чин Баатар (青把都儿, Хөндлэн Дайчин, Баясхалын дэд хүү) хоёр охиноо Хутуг шигүшийн хойч үеийн Чанан (长昂, 贵英)-д, Алтан хаан өөрийн охиноо Хутуг шигүшийн хойч үеийн Энхийн дүү Мэнгүдэйгийн (猛古歹, эхнэр Буянзул伯彦主刺) хүүд, Сэнгэдүүрэн охиноо Хутуг шигүшийн хойч үеийн Шуман (少炒蛮, 把秃赖儿)-д тус тус хатан болгож өгсөн<sup>99</sup>.

“Шар тууж”-д тэмдэглэсэнээр, Гэрсэнзийн том хатан бол Үжээд аймгийн Мөнгүйчийн охин Хатунхай (Хатунгай), баг хатан нь Урианхайн Мэнд (Манд)-ийн охин Мөнгүй (Мөнхүй) юм<sup>100</sup>. “Асрагч нэртийн түүх”-д, Мөнгүйч болон Мэнд хоёрыг бүгд Үжээд аймгийнх гэж тэмдэглэжээ<sup>101</sup>. Д.Гонгорын “Халх товчоон”-д, Мөнгүйчийг Өвөр Халхын Үжээд отгийн ноён хэмээж, Мэндийг “Ар Монголын Урианхай отгийн Мэнд өрлөг” гэжээ<sup>102</sup>. Судлаач Жигачидай Буяндэлгэр бүтээлдээ “Шар туужид буй Гэрсэнзийн хадам эцэг Урианхайн Мэнд өрлөг бол хоёр “Алтан товч”-д бичигдсэн Түлэгэний хөвгүүн Мэнд дархан буюу Горлодын Мэнд өрлөг мөн болох нь лавтай”<sup>103</sup> гэж үзжээ. Энд Түлэгэн бол Тогооч шигүшийн эцэг Дөлгөөн болно. Үүнд, “Шар тууж” болон “Асрагч нэртийн түүх”-д Гэрсэнзийн баг хатан Мөнгүй (Мөнхүй)-гийн эцэг Мэндийг зөвхөн “Мэнд” хэмээн тэмдэглэсэн, харин “Мэнд өрлөг” гэж тэмдэглээгүй юм. “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзангийн “Алтан товч”-д тэмдэглэсэнээр, 1453 оноос өмнө Тайсун хаан Горлодын Цэвдэнд хороогдсоны дараа Горлодын Мэнд өрлөг Цэвдэнг алсан гэдэг. Хэрвээ энэхүү тэмдэглэл үнэн бол, XVI зууны гучаад оны үед Гэрсэнзийг хатан авах насанд Горлодын Мэнд өрлөг бараг 100 гаран настай болно, иймээс энэхүү Гэрсэнзийн хадам эцэг Мэнд нь хоёр “Алтан товч”-д тэмдэглэсэн Мэнд өрлөг биш байна. Тэгвэл Өвөр Халхын үжээд отгийн тухай тэмдэглэсэн Хятадын Мин улсын үеийн түүхийн сурвалж бичиг “Лу лун сай люэ” болон Дармагийн

<sup>98</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг. koku 考部. gungčiuko 贡酋考. Mi wančun 米万春. jimenko 蓟门考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 554-555.

<sup>99</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг. koku 考部. gungčiuko 贡酋考. Mi wančun 米万春. jimenko 蓟门考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 554-555. Josičun 赵时春. beilujiliue 北虜纪略. 明代蒙古汉籍史料汇编. 第一辑. Kökeqota: neimengyudašüecubanše. 2006年. 149.

<sup>100</sup> öljejitütayilbar hijü, Baγan-a hinaba. Erten-nü Mongγol-un qad-un ündüsün-nü yehe šir-a tuγūji oršiba. Begejing: ündüsüten-nü keblehü-ün üildbüri keblebe. 1983. 159.

<sup>101</sup> Жамба, *Асрагч нэртийн түүх*, 阿萨刺克其史. Оюунбилэг орчуулан тайлбарлав 乌云毕力格译注. Kökeqot: neimengyudašüecubanše 内蒙古大学出版社. 2004. 181. 47b.

<sup>102</sup> Гонгор, Д. *Халх товчоон*, Улаанбаатар, 1970. т.174.

<sup>103</sup> Жигачидай Буйндэлгэр, Урианхайн тухай, *Хятад дахь Монгол судлал*, I, Улаанбаатар, 2013. т.78.

“Алтан хүрдэн мянган хэгээст”-д Үжээдийн ноёдын дунд Мөнгүйч болон Мэнд гэсэн нэр байхгүй. “Лу лун сай люэ”-д тэмдэглэснээр, Доянь Урианхайн ноён Хуаданы хойч үеийнхний дунд Бабухай (把卜亥)-гийн хүү Мэнд (Манд, 满都) гэсэн хүн байна<sup>104</sup>. “Хаадын үндэсэн хураангуй алтан товч” болон “Эрдэнэ тунамал нэрт судар оршив”, “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д тэмдэглэсэн “Гурван харуул”-ыг бас “Өлгийн зургаан мянган Үжээд”, “Үжээд улс”, “Зургаан мянган Үжээд”<sup>105</sup> гэдэг, “Шар тууж” болон “Асрагч нэгтийн түүх”-д Гэрсэнзийн хадам эцэг Мэндийг Үжээд буюу Урианхай хэмээн тэмдэглэсэн зэргээс үзвэл, энэхүү Мэнд гэдэг ноён бол Хутуг шигүшийн хойч үеийн ноён болно.

Гэрсэнзийн их хатан Хантухайн эцэг Мөнгүйчийн тухайд мөн “Лу лун сай люэ”-д Хуадангийн хүү Гэрэлтэйгийн дөрөвдүгээр хүү Мокөчи (抹可赤, Мокэчи), “Дэн тань би жоу” 《登坛必究》-д Мэнгүчи (猛古赤, Мөнгүчи) хэмээн тус тус тэмдэглэсэн<sup>106</sup>. “Шар тууж”-д Хантухай хатнаас төрсөн Түмэнхэн абайг Урианхай Лувсанд хатан болгож өгсөн хэмээн тэмдэглэсэн<sup>107</sup>. Тэгвэл, “Лу лун сай люэ”-гийн тэмдэглэлээс үзвэл, Мөкэчигийн дэд хүү нь Лоса (老撒) гэдэг<sup>108</sup>, энэ нь Монголоор Лувсан гэдэгтэй таарах болно. Мөн, “Шар тууж”-д Гэрсэнзийн баг хатан Мөнгүйнээс төрсөн Алтай абайг Урианхай Абантуд хатан болгож өгсөн хэмээн тэмдэглэсэн<sup>109</sup>. Тэгвэл “Лу лун сай люэ”-д Гэрэлтэйгийн зургадугаар хүү Уласхан (兀鲁思罕) Айбөтү (挨伯秃) гэдэг хүүтэй гэж тэмдэглэсэн<sup>110</sup>, энэ нь Монголоор Абантутай таарна. “Шар тууж”-д тэмдэглэснээр, Гэрсэнзийн зургадугаар хүү Дэлдэнгийн баг хатан Ноёнтгойгоос төрсөн Тунгалагжин абайг Урианхайн Бодад

<sup>104</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг kobu 考部. gungčiuko 贡酋考.

<sup>105</sup> *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011, 60а, 05, 60а, 20; Лувсанданзан, *Алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011, 153а, 06, 153а, 17; *Эрдэнэ тунамал нэрт судар оршив*, Жүрүнга орчуулан хянав, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2014, зургаар хэвлэсэн, 9а, 256; Саган Сэцэн, *Хаадын үндэсний Эрдэнийн товч*, Улаанбаатар, 2011, эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, 54v, 08.

<sup>106</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг 卷之十五 kobu 考部. gungčiuko 贡酋考.

<sup>107</sup> öljeitütayilbar hijü, Baγan-a hinaba. Erten-nü Mongγol-un qad-un ündüsün-nü yehe šir-a tuyuǰi oršiba. Begejing: ündüsüten-nü keblehü-ün üildbüri keblebe. 1983. 161.

<sup>108</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг 卷之十五 kobu 考部. gungčiuko 贡酋考.

<sup>109</sup> öljeitütayilbar hijü, Baγan-a hinaba. Erten-nü Mongγol-un qad-un ündüsün-nü yehe šir-a tuyuǰi oršiba. Begejing: ündüsüten-nü keblehü-ün üildbüri keblebe. 1983. 161.

<sup>110</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг 卷之十五 kobu 考部. gungčiuko 贡酋考.



хатан болгож өгсөн<sup>111</sup>. Тэгвэл, “Лу лун сай люэ”-д Гэрэлтэйгийн тавдугаар хүү Дүнхүр (董忽力) Бадан (把当) гэдэг хүүтэй гэж бий<sup>112</sup>, энэ нь Монголоор Бодатой таарах юм. Үүнээс гадна, “Шар тууж”-д тэмдэглэснээр Гэрсэнз болон Гэрсэнзийн хойч үеийнхэн Урианхайн нийт арван хэдэн ноёдтой ургийн холбоо барьсан билээ.

Дээр өгүүлсэн Доянь Урианхайгаас Алтан ургийн хаад, ноёдтой барьсан ургийн холбооноос үзвэл, Гэрсэнз болон Гэрсэнзийн хойч үеийнхэн Доянь Урианхайн ноёдтой хамгийн ихээр худ ургийн холбоо барьсан байна. Энэ нь дээр өгүүлснээр, Гэрсэнзийн ээж Жимсгэн хатан бол Доянь Урианхайн Хутуг шигүшийн охин юм. Доянь Урианхайн ноёд тавнан, шигжин (Хятадын Мин улсын үеийн сурвалж бичиг “Сань юн чоу зү као” 《三云筹俎考》 -д тайлбарласнаар, шигжин (蛇进) бол тавнангийн хөвгүүд гэжээ. Шигжин гэдэг нь ерөнхийдөө Монголын их хааны худ ургийн талын ноёд юм)<sup>113</sup> болсон нь Хутуг шигүшийн дэд хүү Багсунаас эхэлсэн бол энэхүү харилцан уялдсан худ ургийн холбоо нь Баянмөнх жонон болон Орочу шигүшийн охин Шихэр хатнаас эхэлсэн байна.

Дээр өгүүлснээр, Орочу шигүш бол Доянь Урианхайнаас гаралтай, түүний үйл ажиллагаа нь Доянь Урианхайтай ямагт холбоотой байсан бөгөөд тухайн үед Баянмөнх Болху жононг тэтгэж өөрийн охиноо хатан болгон өргөсөн, мөн Монголын олон аймгийн дунд нэр цуутай хүчирхэг удирдагч байжээ. Орочу шигүшийн хүү Хутуг шигүш охиноо Батмөнх Даян хаанд хатан болгон өгсөн нь Хятадын сурвалж бичигт тэмдэглэсэн 1504 онд “Арчиман нэгэн охиноо Батмөнх Даян хаанд хүргэж өгсөн”-тэй таарахыг үзвэл, тухайн цаг үед Арчиман нэгэнт 80, 90-ээд насны өндөр настай байсан тул, түүний хүргэж өгсөн охин бол Хуаданы охин болж таарах бөгөөд Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэж ирсэн Хутуг шигүш бол Хятадын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Хуадантай тохирч байна. “Хаадын үндсэн хураангуй алтан товч” болон Лувсанданзангийн “Алтан товч”-д Орочу шигүшийг Хутугт шигүш хэмээн тэмдэглэсэн боловч, харин “түүний ач охиноос Гэрболд, Гэрсэнз хоёр үзэгдэв” хэмээх тэмдэглэлээс үзвэл, Хятадын талын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэнтэй адил, тухайн цаг үед Орочу шигүш нь амьд сэрүүн байсны илэрхийлэл юм. Тэгвэл Хятадын

<sup>111</sup> öljeiyitüтайлбар hijü, Baγan-a hinaba. Erten-nü Mongγol-un qad-un üндүсүн-nü yehe šir-a туγүји oršiba. Begejing: üндүсүтен-nü keblehü-ün üилдбүри keblebe. 1983. 163.

<sup>112</sup> guezočing 郭造卿, gueyinčung 郭应宠. lulunsailiue 卢龙塞略. 15 дугаар бүлэг 卷之十五 kobu 考部. gungčiuko 贡普考.

<sup>113</sup> Wang šiči 王士琦. sanyünčeuзuko 三云筹俎考. 明代蒙古汉籍史料汇编. 第二辑. kökeqota: neimengyudašüecubanše. 2006. 419.

түүхийн сурвалж бичигт тэмдэглэж ирсэн Хуаданы эцэг Арчиман нь мөн Орочу шигүш болж таарч байна.

Орочу шигүш болон Арчиман хоёрын нэрийн талаар харьцуулан үзэхэд, Мин улсын түүхийн сурвалж бичгүүдэд Орочу шигүшийг “阿渠” “Ачү”, “阿罗出” “Алуочү”, “阿乐出” “Алөчү”, “阿老出” “Алаочү”, “斡罗出” “Волуочү” хэмээн тэмдэглэснээс үзвэл, Мин улсын түүхийн сурвалж бичигт “о”-г “а” гаар, “р”-г “л”гээр авиалж тэмдэглэсэн тохиолдол ихтэй, Арчиман хэмээх нэрийн сүүлийн дуудлага “Ман”-г хасвал “Арчи” нь “ogosi, ogosi” хэмээх дуудлагатай ижил болох бөгөөд “Арчиман” нь Орочу шигүшийн өөр нэгэн нэр гэж үзэж болно. Тэгвэл “Ман” гэдэг нь чухам ямар утга агуулж байгааг үзвэл, “Мин улсын үнэн түүх”-ийн Тианьшүнгийн хоёрдугаар оны арван нэгдүгээр сарын улаан морин өдрийн (天顺二年十一月丙午, 1458 он) тэмдэглэлд, “升朵颜卫都指挥使阿尔古蛮为都督金事。”<sup>114</sup>, “Доянь харуулын доу жи хүй ши Аргуманг Дү дү чянь шигээр дэвшүүлэв” (Энд Аргуман бол Арчиман болох бөгөөд Орочу шигүш болно) хэмээжээ. Мин улсын талаас Орочу шигүш-д анх “доу жи хүй ши” (都指挥使) гэдэг тушаалын цол өгсөн ба Мин улсын төрөөс Доянь Уриананы ноёдод өгсөн тушаалын цолоос үзэхэд, “доу жи хүй ши” нь Монголын талын “мянгат”-тай дүйцнэ. Энэ нь Монголын талаас анх Орочу шигүш Уругуд аймгийг ноёлж байхдаа “мянгат”-ын тушаалтай байсан тул, хятад хэлний дуудлага дээр “ман” хэмээн буусан болов уу.

Мин улсын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн “Хуадан” (花当)-ыг Манж Чин улсын үед зохиогдсон “Илтгэл шастир”-ын Монгол бичгийн хуулбарт “Худун” эсвэл “Худон”, “Хутун”, “Хутон”, “Хотон”, “Хотун” хэмээн тэмдэглэсэн, Хятад хуулбар дээр нь 和通 “Хэтүн” хэмээн тэмдэглэсэн байна<sup>115</sup>. Мин улсын сурвалж бичиг болон Манж Чин улсын “Илтгэл шастир”-ын тэмдэглэсэн нэрийн дуудлага нь ойролцоо бөгөөд бүгд эргэлзээтэй, харин Монголын түүхийн сурвалж бичигт тэмдэглэсэн Хутуг гэх нэр нь оновчтой юм.

### Дүгнэлт

Уругуд аймаг бол Доянь Урианхай аймгийн харьяат аймаг бөгөөд Орочу шигүш бол Доянь Урианхайн нэг ноён мөн байна. Батмөнх Даян хаанаас Урианхай ноёдтой тогтоосон ургийн холбоо бол Доянь Урианхайн ноёдтой тогтоосон ургийн холбоо юм. Орочу шигүш бол Хутуг шигүшийн эцэг байсан нь тодорхой бөгөөд

<sup>114</sup> Min yingzūng shilu 明英宗实录, 297 бүлэг. Тианьшүнгийн хоёрдугаар оны арван нэгдүгээр сарын улаан морин өдөр. Taiwan: 中央研究院历史语言研究所.

<sup>115</sup> *Илтгэл шастир*, Монгол хуулбар, 23 дугаар дэвтэр, 7.

улмаар энэхүү хоёр хүн бол Хятадын түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн Доянь Урианхайн ноён Арчиман, Хуадан нар ажээ. Доянь Урианхайн ноёдоос Баянмөнх Болху жинон болон Батмөнх Даян хаантай тогтоосон Ургийн холбоонь Доянь Урианхайн ноёд түүхийн сурвалж бичгүүдэд “тавнан”, “шигжин нар” хэмээн алдаршсан учир шалтгааныг тодорхойлж байна. Урьдах зарим судлаач Доянь Урианхайг Хятадын Мин улсын харьяат болсон гэж дүгнэсэн бол, энд Доянь Урианхай бол Монголын хаан төрд харьяалагдаж байсныг улам лавшруулав.

### ABSTRACT

The Orochu shigush and Khutug shigush played very important role in history of Mongolia from the middle 15th century to the middle 16th century. About this two man, Record of every Mongolian historical since 17<sup>th</sup> century was different. According to the different historical records, researchers explained their relationship and subordination is differently. Based on previous historical records of Mongolian and China's Ming dynasty, this thesis aimed to explain relationship between the Orochu shigush and Khutug shiguch, theirs subordination too.

### Ашигласан сурвалж бичиг

1. Монголын нууц товчоо
2. *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011.
3. Лувсанданзан, *Алтан товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн Ш.Чоймаа, хянан тохиолдуулсан М.Баярсайхан, Улаанбаатар, 2011.
4. Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*, эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар, 2011, т.481. 58v.
5. *Эрдэнэ тунамал нэрт судар оршив*, 《阿拉坦汗传》. 朱荣嘎译注. 内蒙古大学出版社. 2014年2月.
6. Жамба, *Асрагч нэртнийн түүх*; Саган Сэцэн, *Хаадын үндэсний эрдэнийн товч*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн М.Баярсайхан, хянан тохиолдуулсан Ш.Чоймаа, Улаанбаатар. 2011.
7. *Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж*, Эх бичгийн цогц судалгаа хийсэн С.Чулуун, Ш.Цэрэндоо, Улаанбаатар. 2011.

8. Рашпунцаг, *Болор эрих*, Өвөр Монголын хэвлэлийн хороо, 2000.
9. Лувсандамбийжалсан, *Их Монгол улсын үндсэн алтан товч тууж оривой*, 《大蒙古国根本黄金史》. 内蒙古大学出版社. 2014 年.
10. Ломи. 罗密. 《蒙古博尔济忒氏族谱》. 内蒙古大学出版社. 2014 年.
11. Дарма, *Алтан хүрдэн мянган хэгээст*, Чойж хянав, Өвөр Монголын хэвлэлийн хороо. 2000.
12. Раш-Ад-дин, *Судрын чуулган*.
13. 宋濂. 《元史》. 北京. 中华书局.
14. 《明实录》. 台湾. 中央研究院历史语言研究所.
15. 马文升. 《西征石城记》. 《明代蒙古汉籍史料汇编》. 第一辑. 内蒙古大学出版社. 2006年.
16. 张雨. 《边政考》. (节录). 《明代蒙古汉籍史料汇编》. 第一辑. 内蒙古大学出版社. 2006年.
17. 王琼. 《北虏事迹》. (节录). 《明代蒙古汉籍史料汇编》. 第一辑. 内蒙古大学出版社. 2006年.
18. 徐日久. 《五边典则》. (卷之一). 《明代蒙古汉籍史料汇编》. 第五辑. 内蒙古大学出版社.
19. 方孔炤. 《明全边略记》. (卷之四陕西延绥略固原在内). 《明代蒙古汉籍史料汇编》. 第三辑. 内蒙古大学出版社. 2006年.
20. 张鼐《辽夷略》. 《明代蒙古汉籍史料汇编》第二辑. 内蒙古大学出版社. 2006.
21. 陈组绶. 《皇明职方地图》. 卷中.
22. 魏焕. 《九边考》(节录). 《明代蒙古汉籍史料汇编》. 第一辑.. 内蒙古大学出版. 2006.
23. 马文升. 《西征石城记》. 《明代蒙古汉籍史料汇编》. 第一辑. 内蒙古大学出版社. 2006年.
24. 叶向高. 《四夷考》. (节选). 《明代蒙古汉籍史料汇编》. 第二辑. 内蒙古大学出版社. 2006年.
25. 《满文老档》. 东洋文库 . 1959.
26. *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүннүүдийн илтгэл шастир* 《王公表传》.

**Ашигласан ном бүтээлүүд**

1. С.Бадамхатан, *БНМАУ-ын угсаатны зүй*, Улаанбаатар, 1987.
2. *Монгол улсын түүх*, гутгаар боть, Улаанбаатар, 2003.
3. А.Очир, “Урианхай нарын угсаа-түүхийн асуудал”, *Түүхийн судлал*, Томус XXXII, Улаанбаатар, 2000.
4. Л.Жамсран, *Монгол улсын түүх*, гутгаар боть, Улаанбаатар, 2003.
5. Ц.Гантулга, *Алтайн Урианхайчууд*, Улаанбаатар, 2004.
6. 和田清. 「東亜史研究・蒙古篇」. 東洋文庫. 1958.
7. 岡田英弘. 「ウリヤンハン・モンゴル族の滅亡」. 『榎博士頌寿記念東洋史論叢』. (汲古書院). 東京. 1988 .11.11 .43-58.
8. 乌兰. 《蒙古源流》研究. 辽宁省民族出版社. 2000年 1月.
9. 胡日查. 《有关朵颜卫者勒蔑家族史实》. 内蒙古社会科学. 2000. 1.
10. 乌云毕力格. 《内蒙古通史》. 第四卷. 人民出版社. 2011年第一版.
11. 乌云毕力格. 《〈金轮千福〉所载扎鲁特蒙古》. 西北民族大学学报. 2010 . 6.
12. 乌云毕力格. 《关于朵颜兀良哈人的若干问题》. 《蒙古史研究》第七辑. 2013年.
13. 乌兰. 《蒙古源流》研究. 辽宁省民族出版社. 2000年 1月.
14. 达力扎布. 《明清蒙古史论稿》. 民族出版社. 2004.
15. 杜家骥. 《〈蒙古家谱〉增修者博清额之家世及该族〈蒙古博尔济吉忒氏族谱〉、〈恩荣奕叶〉》. 《蒙古史研究》辑刊. 2003年.
16. 贾敬颜《五投下的遗民》.
17. 玉芝. 《蒙古东道诸王及其后裔所属部众历史研究》. докторын диссертаци.